



УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2023 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2023 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 08-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

НЭГДСЭН ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

*Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дээрх
QR кодыг уншуулан танилцах боломжтой.*

**НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН
АГУУЛГА**

2023 оны 11 дүгээр сарын 08-ны өдөр, Лхагва гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	1
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	2 - 14
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	15 - 50

1.	<i>Монгол Улсын 2024 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2023.09.29-ний өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг/</i>	15 - 24
2.	<i>Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.09.29-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/</i>	24 - 34
3.	<i>Монгол Улсын 2024 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2023.09.29-ний өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, үргэлжлэл/</i>	34 - 50

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы
11 дүгээр сарын 08-ны өдөр /Лхагва гараг/-ийн нэгдсэн
хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 72 гишүүнээс 41 гишүүн хүрэлцэн ирж, 56.9 хувийн ирцтэйгээр хуралдаан 14 цаг 03 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.

Томилолттой: Т.Аубакир, Д.Өнөрболор, Н.Энхболд;

Чөлөөтэй: Ё.Баатарбилэг, Б.Баярсайхан, Л.Оюун-Эрдэнэ;

Эмнэлгийн чөлөөтэй: Ж.Сүхбаатар;

Тасалсан: Ц.Анандбазар, С.Батболд, С.Ганбаатар, Ц.Идэрбат, Ч.Ундром, Д.Цогтбаатар, Т.Энхтүвшин;

Хоцорсон: Г.Амартүвшин – 20 минут, Д.Батлут – 02 минут, Ж.Батсуурь – 05 минут, Б.Баттөмөр – 02 минут, Б.Бейсен – 02 минут, Х.Булгантуяа – 39 минут, Д.Ганбат – 51 минут, Х.Ганхуяг – 04 минут, Ц.Даваасүрэн – 07 минут, Г.Дамдинням – 04 минут, Б.Дэлгэрсайхан – 01 минут, Б.Жаргалмаа – 01 минут, Л.Мөнхбаатар – 06 минут, Ц.Мөнх-Оргил – 11 минут, Ц.Сэргэлэн – 05 минут, Ц.Туваан – 10 минут, Н.Учрал – 07 минут, О.Цогтгэрэл – 01 минут, Ж.Чинбүрэн – 01 минут, Б.Энх-Амгалан – 01 минут, Б.Энхбаяр – 22 минут, Ж.Эрдэнэбат – 06 минут.

Нэг.Монгол Улсын 2024 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2023.09.29-ний өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Сангийн дэд сайд С.Мөнгөнцэцэг, Монгол Улсын Ерөнхий Аудиторын орлогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Санхүү-Нийцлийн аудитын газрын захирал, Тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, Үндэсний аудитын газрын Аудитын нэгдсэн удирдлага, зохицуулалтын газрын захирал, Тэргүүлэх аудитор Я.Самбууням, Үндэсний аудитын газрын Гүйцэтгэл-Нийцлийн аудитын газрын захирал, Тэргүүлэх аудитор Д.Энхболд, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, мөн яамны Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Санхүү, төсвийн судалгааны газрын дарга Г.Золбоо, Санхүүгийн бодлогын газрын дарга Б.Сүх-Очир, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ч.Чимидсүрэн, Төсвийн нэгтгэлийн хэлтсийн дарга Э.Батмөнх, Төсвийн зарлагын хэлтсийн дарга П.Бат-Эрдэнэ, Төсвийн орлогын хэлтсийн дарга Л.Ичинноров, Санхүүгийн хөрөнгийн удирдлагын хэлтсийн дарга С.Тулга, Төсвийн хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Ж.Дэлгэржаргал, Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Б.Ганзориг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ц.Баянмөнх, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул, Хяналт шалгалт, үнэлгээний газрын дарга С.Ганболд, мөн газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн дарга Д.Эрдэнэсамбуу нар байлцав.

Төслүүдийг хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн дарга Д.Тогтохсүрэн, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн дарга О.Цогтгэрэл, Төсвийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан төсвийн саналуудыг холбогдох хуулийн шаардлага хангасан эсэх талаарх дүгнэлтийг Улсын Их Хурлын Тамгын газрын Хяналт шалгалт, үнэлгээний газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн дарга Д.Эрдэнэсамбуу нар танилцуулав.

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслүүдийн хоёр дахь хэлэлцүүлэгтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн дарга О.Цогтгэрэл ажлын 2 өдрийн завсарлага авах тухай мэдэгдэж, уг асуудлаар Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар 2 цагийн завсарлага өгөв./14:30/

Уг асуудлыг 14 цаг 30 минутаас завсарлага өгөв.

Хоёр. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.09.29-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Сангийн дэд сайд С.Мөнгөнцэцэг, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, мөн яамны Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Санхүү, төсвийн судалгааны газрын дарга Г.Золбоо, Санхүүгийн бодлогын газрын дарга Б.Сүх-Очир, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ч.Чимидсүрэн, Төсвийн нэгтгэлийн хэлтсийн дарга Э.Батмөнх, Төсвийн зарлагын хэлтсийн дарга П.Бат-Эрдэнэ, Төсвийн орлогын хэлтсийн дарга Л.Ичинноров, Санхүүгийн хөрөнгийн удирдлагын хэлтсийн дарга С.Тулга, Төсвийн хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Ж.Дэлгэржаргал, Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Б.Ганзориг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ц.Баянмөнх, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул, Хяналт шалгалт, үнэлгээний газрын дарга С.Ганболд, мөн газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн дарга Д.Эрдэнэсамбуу нар байлцав.

Төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн дарга Д.Тогтохсүрэн танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Тувааны тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн, Төсвийн байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж, Б.Баттөмөр нар үг хэлэв.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Төсвийн байнгын хорооны дэмжсэн санал:

Г.Занданшатар: 1.Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн, Ш.Адъяаа, П.Анужин, Т.Аубакир, Э.Бат-Амгалан, Ж.Батсуурь, Б.Баярсайхан, Г.Дамдинням, М.Оюунчимэг, Б.Пүрэвдорж, Ц.Сэргэлэн, Ц.Туваан, Г.Тэмүүлэн, Д.Цогтбаатар, Ц.Цэрэнпунцаг, Н.Энхболд, Ж.Эрдэнэбат /цаашид “Ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын хэмжээ /тэрбум төгрөг/ 2024 онд “25.289.8” гэснийг “25.855.1” гэж, Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь 2024 онд “34.2” гэснийг “34.9” гэж, Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл /тэрбум төгрөг/ 2024 онд “-2.070.8” гэснийг “-1.505.4” гэж, Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь 2024 онд “-2.8” гэснийг “-2.0” гэж, Нэгдсэн төсвийн хөрөнгийн зардлын хэмжээ 2024 онд “6.170.4” гэснийг “6.273.3” гэж, Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь 2024 онд “8.3” гэснийг “8.5” гэж, Нийгмийн халамжийн тухай хуульд заасны дагуу төсвөөс санхүүжүүлэх зардлын нийт хэмжээ /тэрбум төгрөг/ 2024 онд “2.389.6” гэснийг “2.351.9” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулав.

Зөвшөөрсөн: 39
Татгалзсан: 16
Бүгд: 55
70.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хурааж дууслаа.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаан 14 цаг 51 минутад завсарлаж, 16 цаг 32 минутаас Монгол Улсын 2024 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг үргэлжлүүлэн хэлэлцэв.

Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн дарга О.Цогтгэрэл хуулийн төслүүдийн хоёр дахь хэлэлцүүлэгтэй холбогдуулан үг хэлж, Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгээс авсан завсарлага дууссаныг мэдэгдэв./16:37/

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслүүдийн талаарх Төсвийн байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Төсвийн байнгын хорооны дэмжсэн санал:

**НЭГ.ТӨСВИЙН ТЭНЦЭЛ САЙЖРУУЛАХТАЙ ХОЛБООТОЙ
ТӨСВИЙН ОРЛОГО НЭМЭГДҮҮЛЭХ САНАЛ:**

1.Төсвийн орлого нэмэгдүүлэх санал:

Дүн: 590,761.3 сая төгрөг

Г.Занданшатар: Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн, Ш.Адьяа, П.Анужин, Т.Аубакир, Э.Бат-Амгалан, Ж.Батсуурь, Б.Баярсайхан, Г.Дамдинням, М.Оюунчимэг, Б.Пүрэвдорж, Ц.Сэргэлэн, Ц.Туваан, Г.Тэмүүлэн, Д.Цогтбаатар, Ц.Цэрэнпунцаг, Н.Энхболд, Ж.Эрдэнэбат /цаашид “Ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан, 1.1.Олон жил хуримтлагдсан татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн төлбөрийн өрийг үе шаттай барагдуулж, төсвийн тогтвортой байдлыг хангах, иргэдийн цалин, тэтгэвэр, тэтгэмж, төрийн үйлчилгээний зардлын санхүүжилтийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах зорилгоор аж ахуйн нэгжийн орлогын албан татварын 2022 оноос өмнөх хуримтлагдсан өр төлбөрийг 20-иос доошгүй хувь буюу 92,100.0 сая төгрөгөөр, нэмэгдсэн өртгийн албан татварын хуримтлагдсан өр төлбөрийг 20-иос доошгүй хувь буюу 194,300.0 сая төгрөгөөр, нийгмийн даатгалын шимтгэлийн хуримтлагдсан өр төлбөрийг 50-иас доошгүй хувь буюу 256,361.3 сая төгрөгөөр тус тус барагдуулж, улсын төсвийн орлогыг 542,761.3 сая төгрөгөөр нэмэгдүүлэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж үг хэлэв.

Зөвшөөрсөн: 38
Татгалзсан: 17
Бүгд: 55
69.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Г.Занданшатар: 1.2.Ажлын хэсгийн гаргасан, Ирээдүйн өв сангийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1 дэх заалтад зааснаас бусад төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн үр ашгийг нэмэгдүүлэх, цар тахлын үед төвлөрүүлээгүй ногдол ашгийн үлдэгдлийг бүрэн дайчлах замаар улсын төсөвт 48,000.0 сая төгрөгийг нэмж төвлөрүүлэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 37
Татгалзсан: 17
Бүгд: 54
68.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

ХОЁР.ТӨСВИЙН ЗАРДАЛ НЭМЭГДҮҮЛЭХ, БУУРУУЛАХ САНАЛ:

2.1.Төсвийн зардал бууруулах санал:

Дүн: 346,154.2 сая төгрөг

Г.Занданшатар: 2.1.1.Ажлын хэсгийн гаргасан, Нэгдсэн төсвийн ерөнхийлөн захирагчдын төсвийн төслийн нийт зарлагын зээлийн хүүгийн төлбөр, үйл ажиллагааны орлогоос бүрэн санхүүждэг зардлаас бусад урсгал зардлыг 1.88 хувиар буюу 320,416.0 сая төгрөгөөр бууруулах;

2.1.2.Орчны бохирдлыг бууруулах үндэсний хороог татан буулгасантай холбогдуулан Эрчим хүчний сайдын төсвийн багцын урсгал зардлыг 25,738.2 сая төгрөгөөр бууруулах;

2.2.Төсвийн урсгал зардал нэмэгдүүлэх санал:

Дүн: 226,622.3 сая төгрөг

Г.Занданшатар: 2.2.1.Ажлынх хэсгийн гаргасан, Монгол Улсын сайд, Боомтын сэргэлтийн Үндэсний хорооны ажлын албаны үйл ажиллагааны урсгал зардлыг 1,000.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх;

2.2.2.Улсын төсвөөс Говьсүмбэр аймагт олгох санхүүгийн дэмжлэгийн хэмжээг 1,000.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх;

2.2.3.Орчны бохирдлыг бууруулах үндэсний хороог татан буулгасантай холбогдуулан Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын төсвийн багцын орчны бохирдлыг бууруулах үйл ажиллагааны зардлыг 26,238.2 сая төгрөгөөр нэмэгдүүлэх;

2.2.4.Орон нутаг, хөдөөгийн багуудын хөгжил, үйл ажиллагааг дэмжих зорилгоор хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээнд зориулж Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын төсвийн багцын Сум, багийн хөгжлийг дэмжих үйл ажиллагааны зардлыг Төв аймагт 300.0 сая төгрөг, Ховд аймагт 300.0 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлэх;

2.2.5.Аймгийн номын сангийн номын фондыг баяжуулах зорилгоор Соёлын сайдын төсвийн багцын номын зардлыг Төв аймагт 100.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх;

2.2.6.Сэлэнгэ аймгийн ерөнхий боловсролын сургуулийн номын сангийн фондыг баяжуулах зорилгоор Боловсрол, шинжлэх ухааны сайдын төсвийн багцын номын зардлыг 175.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх;

2.2.7.Үндсэн хуулийн цэц, шүүх, прокурорын 2016 оноос хойш нэмэгдүүлээгүй цалин хөлсийг нэмэгдүүлэхтэй холбоотойгоор Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн даргын төсвийн багцын цалингийн санг 233.0 сая төгрөгөөр, Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн төсвийн багцын цалингийн санг 640.5 сая төгрөгөөр, Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын төсвийн багцын цалингийн санг 11,100.1 сая төгрөгөөр, Шүүхийн сахилгын хорооны даргын төсвийн багцын цалингийн санг 198.1 сая төгрөгөөр, Улсын ерөнхий прокурорын төсвийн багцын цалингийн санг 17,506.1 сая төгрөгөөр тус тус, нийт 29,677.8 сая төгрөгөөр нэмэгдүүлэх;

2.2.8.Макро эдийн засгийн үндсэн үзүүлэлт, төлөв байдлын таамаглалыг боловсруулах чиг үүргийг хэрэгжүүлэх зорилгоор Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн үйл ажиллагааны зардлыг 800.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх;

2.2.9.Удирдлагын академид төрийн албан хаагчдыг сургах, хөгжүүлэх, чадавхжуулах үйл ажиллагаатай холбогдуулан Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын төсвийн багцын урсгал зардлыг 3,561.7 сая төгрөгөөр нэмэгдүүлэх;

2.2.10.Стандартчилал, хэмжил зүйн үндэсний төвийн урвалж бодисын зардалд зориулан Шадар сайдын төсвийн багцын урсгал зардлыг 500.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх;

2.2.11.Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын төсвийн багцын урсгал зардлыг 8,108.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх;

2.2.12.2024 онд Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийг нэмэгдүүлэх зорилгоор Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын төсвийн багцын Нийгмийн даатгалын санд олгох татаасыг 140,661.6 сая төгрөгөөр нэмэгдүүлэх;

2.2.13.Аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлгийн тогтмол зардлыг санхүүжүүлэхтэй холбоотойгоор аймгуудын тогтмол зардлыг 14,200.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх.

2.3.Хөрөнгийн зардалд өөрчлөлт оруулах санал:

Цэвэр өөрчлөлтийн дүн: 118,750.3 сая төгрөг

2.3.1.Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн төслийн 2 дугаар хавсралтад тусгагдсан 9 төсөл, арга хэмжээний 2024 онд санхүүжих дүнг хэрэгжилт, гүйцэтгэлийн явцтай уялдуулан 98,000.0 сая төгрөгөөр саналын томьёоллын 1 дүгээр хавсралтын дагуу бууруулах.

2.3.2.Саналын томьёоллын 2 дугаар хавсралтад тусгагдсан 800,889.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 245,012.9 сая төгрөгийн 2024 онд санхүүжих дүнтэй 212 төсөл, арга хэмжээг 2024 оны төсвийн төсөлд шинээр нэмж тусгах.

2.3.3.Төсвийн төсөлд тусгагдсан 25 төсөл, арга хэмжээний төсөвт өртгийг 30,537.8 сая төгрөгөөр, 2024 онд санхүүжих дүнг 21,025.7 сая төгрөгөөр саналын томьёоллын 3 дугаар хавсралтын 1 дэх хэсэгт тусгасны дагуу, 11 төсөл, арга хэмжээний төсөвт өртгийг 203,858.7 сая төгрөгөөр саналын томьёоллын 3 дугаар хавсралтын 2 дахь хэсэгт тусгасны дагуу, 11 төсөл, арга хэмжээний 2024 онд санхүүжих дүнг 19,991.1 сая төгрөгөөр саналын томьёоллын 3 дугаар хавсралтын 3 дахь хэсэгт тусгасны дагуу тус тус нэмэгдүүлэх, мөн саналын томьёоллын 3 дугаар хавсралтын 4 дэх хэсэгт тусгасан 2 төслийн төсөвт өртгийг 34,992.7 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 2024 оны санхүүжих дүнг 3,000.0 сая төгрөгөөр бууруулах.

2.3.4.Монгол Улсын тухайн жилийн төсвийн тухай хуулиар өмнө нь батлагдан хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээний төсөвт өртгийн магадлалд хийсэн Үндэсний аудитын газрын аудитын дүгнэлтэд үндэслэн саналын томьёоллын 4 дүгээр хавсралтын 1 дэх хэсэгт

тусгагдсан 284,078.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 18,604.3 сая төгрөгийн 2024 онд санхүүжих дүнтэй 51 төсөл, арга хэмжээг 2024 оны төсвийн төсөлд шинээр нэмж тусгах, мөн төсвийн төсөлд тусгагдсан саналын томьёоллын 4 дүгээр хавсралтын 2 дахь хэсэг дэх 61 төсөл, арга хэмжээний төсөвт өртгийг 115,698.0 сая төгрөгөөр, 14 төсөл, арга хэмжээний 2024 онд санхүүжих дүнг 10,489.1 сая төгрөгөөр нэмэгдүүлэх, мөн төсвийн төсөлд тусгагдсан саналын томьёоллын 4 дүгээр хавсралтын 3 дахь хэсэг дэх 2 төсөл, арга хэмжээний төсөвт өртөг болон 2024 онд санхүүжих дүнг 738.6 сая төгрөгөөр тус тус бууруулах.

2.3.5.Төсвийн төсөлд тусгагдсан 8 төсөл, арга хэмжээний төсөвт өртгийг 7,773.8 сая төгрөгөөр, 2024 онд санхүүжих дүнг 5,873.8 сая төгрөгөөр саналын томьёоллын 5 дугаар хавсралтын 1 дэх хэсэгт тусгасны дагуу, 51 төсөл, арга хэмжээний 2024 онд санхүүжих дүнг 71,820.7 сая төгрөгөөр саналын томьёоллын 5 дугаар хавсралтын 2 дахь хэсэгт тусгасны дагуу бууруулах.

2.3.6.Саналын томьёоллын 6 дугаар хавсралтад тусгагдсан 32,480.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 16,939.9 сая төгрөгийн 2024 онд санхүүжих дүн бүхий 15 төсөл, арга хэмжээг 2024 оны төсвийн төслөөс хасах.

2.3.7.Төсвийн төсөлд тусгагдсан төсөвт өртөг болон 2024 онд санхүүжих дүнд нөлөөлөхгүйгээр 33 төсөл, арга хэмжээний нэр, байршил, хүчин чадлыг саналын томьёоллын 7 дугаар хавсралтад тусгасны дагуу өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж, Б.Баттөмөр, Г.Ганболд, Д.Тогтохсүрэн нар үг хэлэв.

Улсын Их Хурлын дэд дарга Л.Мөнхбаатар 17 цаг 14 минутаас хуралдааныг даргалав.

Зөвшөөрсөн: 32
Татгалзсан: 20
Бүгд: 52

61.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

ГУРАВ.ЗАРЧМЫН БУСАД САНАЛ:

3.1.Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн төсөлд өөрчлөлт оруулах:

Л.Мөнхбаатар: 3.1.1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 10 дугаар зүйлийн “1,231,447.7 сая төгрөг,” гэснийг “1,231,447.7 сая төгрөг байна.” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 36
Татгалзсан: 17
Бүгд: 53

67.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.1.2.Төслийн 11 дүгээр зүйлийн “2,788,332.7 сая төгрөг,” гэснийг “2,788,332.7 сая төгрөг байна.” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 36
Татгалзсан: 18
Бүгд: 54
66.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.2.Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн төслийн 1 дүгээр хавсралтад өөрчлөлт оруулах:

Л.Мөнхбаатар: 3.2.1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын гарчгийг “Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2024 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлт” гэж, мөн хавсралтын 11.1 дэх хэсгийн “70102 Хууль тогтоох, хуулийн хэрэгжилтэд хяналт тавих” гэснийг “70204 Санхүүгийн зах зээлийн зохицуулалт” гэж, 11.2 дахь хэсгийн “Хөтөлбөр” баганын “11.2.1, 11.2.2” гэсэн дугаарыг “11.1.3, 11.1.4” гэж, 16.2 дахь хөтөлбөрийн 16.2.5 дахь хэсгийн “2024 оны зорилтот түвшин” баганын “Илтгэх хуудас” гэснийг “Илтгэх хуудас-1” гэж, 20.5.1 дэх хөтөлбөрийн 20.5.1.1 дэх хэсгийн “2024 оны зорилтот түвшин” баганын “7” гэснийг “300/7” гэж, 20.6.1 дэх хөтөлбөрийн “Шалгуур үзүүлэлт” баганын “цэвэрлэгээний ажлын хэмжээ” гэснийг “цэвэрлэгээ” гэж, 21.1.2 дахь хөтөлбөрийн “Хөтөлбөрийн зорилт, хүрэх үр дүн” баганын “өргөжихийн хирээр” гэснийг “өргөжүүлж” гэж, 21.2.1 дэх хөтөлбөрийн “2024 оны зорилтот түвшин” баганын “5.0” гэснийг “6.0” гэж, 23.5.1 дэх хөтөлбөрийн 23.5.1.5 дахь хэсгийн “2024 оны зорилтот түвшин” баганын “45,700.0” гэснийг “45,000.0” гэж, 23.8.1 дэх хөтөлбөрийн “Шалгуур үзүүлэлт баганын “хууль” гэснийг “хуулийн төсөл” гэж, 26.6.1 дэх хөтөлбөрийн 26.6.1.5 дахь хэсгийн “Хэмжих нэгж” гэсэн баганын “жин” гэснийг “хувь” гэж, 28.3.1 дэх хөтөлбөрийн 28.3.1.1 дэх хэсгийн “2024 оны зорилтот түвшин” баганын “51.1” гэснийг “65.3” гэж, 29.3.1 дэх хөтөлбөрийн 29.3.1.1 дэх хэсгийн “хууль” гэснийг “хуулийн төсөл” гэж, 36.1.1 дэх хөтөлбөрийн 36.1.1.1 дэх хэсгийн “хамрагдаж” гэснийг “хамрагдсан хүмүүст” гэж, 37.1.1 дэх хөтөлбөрийн 37.1.1.1, 37.1.3 дахь хөтөлбөрийн 37.1.3.1, 37.1.3.3 дахь хэсгийн “хувь” гэснийг “явц” гэж, 38.1 дэх хэсгийн “70501 Орон нутгийн төсөвт олгох орлогын шилжүүлэг” гэснийг “71105 Авто тээврийн хяналт, зохицуулалт, үйлчилгээ, нийтийн тээвэр” гэж тус тус өөрчлөх, хөтөлбөр, хөтөлбөрийн зорилт, хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлтэд өөрчлөлт орсонтой холбогдуулан дугаарлалтын өөрчлөлт оруулах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 36
Татгалзсан: 18
Бүгд: 54
66.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Л.Мөнхбаатар: 3.2.2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын 11.2 дахь хэсгийн “70104 Ерөнхийлөгч, хууль тогтоох болон гүйцэтгэх засаглалын удирдлагын судалгаа шинжилгээ” гэснийг, мөн хэсгийн “11.2” гэсэн дугаарыг, 28.1 дэх хэсгийн 28.1.2 дахь хөтөлбөр буюу “Нийт мал сүрэгт өндөр ашиг шимт малын эзлэх хувийг нэмэгдүүлнэ.” гэсэн зорилт, хүрэх үр дүнг 28.1.2.1, 28.1.2.2 дахь хэсгийн шалгуур үзүүлэлт, хэмжих нэгж, суурь он, суурь түвшин, 2024 оны зорилтот түвшингийн хамт бүхэлд нь, 28.4 дэх хэсгийн 28.4.1 дэх

хөтөлбөрийн 28.4.1.3 дахь хэсгийн “Дорнод үйлдвэрлэл технологийн паркийн бүтээн байгуулалтын явц” гэсэн шалгуур үзүүлэлтийг хэмжих нэгж, суурь он, суурь түвшин, 2024 оны зорилтот түвшингийн хамт бүхэлд нь, 34.1.1 дэх хөтөлбөрийн 34.1.1.1 дэх хэсгийн “мянгаар” гэснийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 37
Татгалзсан: 16
Бүгд: 53

69.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Л.Мөнхбаатар: 3.2.3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 9.1.3 дахь хөтөлбөрийн “Шалгуур үзүүлэлт” баганын “төлөвлөгөөний” гэсний дараа “тухайн оны” гэж, 29.7.1 дэх хөтөлбөрийн 29.7.1.3 дахь хэсгийн “нээсэн” гэсний дараа “хүүхдэд” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 35
Татгалзсан: 18
Бүгд: 53

66.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.3.Бусад санал:

Л.Мөнхбаатар: 3.3.1.Ажлын хэсгийн гаргасан, Орлого нэмэгдүүлэх, урсгал зардал болон хөрөнгийн зардалд өөрчлөлт орж байгаатай холбогдуулан Төсвийн ерөнхийлөн захирагч нарын төвлөрүүлэх орлого, зарцуулах зардалд болон орон нутгаас улсын төсөвт төвлөрүүлэх орлого, орон нутагт улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгийн хэмжээг саналын томъёололтой уялдуулан тооцоолол хийж, хуулийн дагуу холбогдох өөрчлөлтийг хийх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 39
Татгалзсан: 14
Бүгд: 53

73.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Л.Мөнхбаатар: 3.3.2.Ажлын хэсгийн гаргасан, Төсөлд зүйл, заалт нэмэгдэх, хасагдах, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төсөвт өртөг, санхүүжих дүнд өөрчлөлт оруулах, нэр, хүчин чадал, байршлыг өөрчилсөнтэй уялдуулан хуулийн төслийн дугаарлалт, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний дугаар, хэрэгжих хугацаа, эдийн засгийн ангилал, Төсвийн ерөнхийлөн захирагч хооронд холбогдох өөрчлөлтийг оруулах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 37
Татгалзсан: 16
Бүгд: 53

68.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Л.Мөнхбаатар: 3.3.3.Ажлын хэсгийн гаргасан, Төсөлд шинээр тусгагдсан төсөл, арга хэмжээний төслийн кодыг Сангийн яамны төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим системээс бэлтгэн төслийн 2 дугаар хавсралтын “Төслийн код” баганад харгалзуулан тусгах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	36
Татгалзсан:	17
Бүгд:	53

67.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Л.Мөнхбаатар: 3.3.4.Ажлын хэсгийн гаргасан, Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн төслийн хамт өргөн мэдүүлсэн Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хонины ноос, тэмээний ноос, сарлагийн хөөврийн килограмм тутамд тооцон мөнгөн урамшуулал олгохоор төсвийн тооцоололд тусгагдсантай холбогдуулан Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 40 дүгээр зүйлд заасныг үндэслэн Улсын Их Хурлын 2011 оны 30 дугаар тогтоолын холбогдох заалтад өөрчлөлт оруулах Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулж Байнгын хороо, нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	40
Татгалзсан:	12
Бүгд:	52

76.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Л.Мөнхбаатар: 3.3.5.Ажлын хэсгийн гаргасан, Төсвийн шинэчлэл болон төсвийн тооцоололд өөрчлөлт орсонтой холбоотой, мөн Монгол Улсын 2024 оны төсвийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн төслүүдийн хэлэлцүүлгийн явцад гарсан саналын томъёололтой холбогдуулан Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 40 дүгээр зүйлд заасныг үндэслэн холбогдох хууль тогтоомжийн төслийг боловсруулж Байнгын хороо, нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	37
Татгалзсан:	15
Бүгд:	52

71.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Л.Мөнхбаатар: 3.3.6.Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдоржийн гаргасан, Саналын томъёоллын 2 дугаар хавсралтад тусгагдсан “Шинэ сэргэлт” Ховд төслийн тоног төхөөрөмж /Ховд/ төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 40.9 сая төгрөгөөр бууруулж, хөрөнгө оруулалтын хавсралтад Өв соёл, хүндэтгэлийн өргөө /Ховд, Үенч сум/, хэрэгжих хугацаа 2020-2024, төсөвт өртөг 150.0 сая төгрөг, 2024 онд санхүүжих дүн 40.9 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг нэмэгдүүлэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	36
Татгалзсан:	16
Бүгд:	52

69.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Л.Мөнхбаатар: 3.3.7.Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяагийн гаргасан, Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн төслийн 2 дугаар хавсралтын IX.1.3.1-д тусгагдсан “Гаалийн шинэчлэл-Гаалийн ерөнхий газар, газар хороодын шуурхай удирдлагын төв, хяналт шалгалтын тоног, төхөөрөмж, дэд бүтцийн хамт /Улсын хэмжээнд/” гэсэн төсөл, арга хэмжээний 2024 онд санхүүжих дүнг 500.0 сая төгрөгөөр бууруулж, хөрөнгө оруулалтын хавсралтад “Сумын төвын доторх 1.5 км хатуу хучилттай авто зам /Архангай, Хайрхан сум/, хэрэгжих хугацаа 2024-2026, төсөвт өртөг 1,500.0 сая төгрөг, 2024 онд санхүүжих дүн 500.0 сая төгрөг” гэсэн төсөл арга хэмжээг нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 39

Татгалзсан: 13

Бүгд: 52

75.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Төсвийн байнгын хорооны дэмжээгүй санал:

НЭГ.БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН ХОРОО

Л.Мөнхбаатар: 1.Улсын Их Хурлын гишүүн Ц.Анандбазарын гаргасан, Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн төслийн 2 дугаар хавсралтын “VI.I.8.Аялал жуулчлалын байгаль, түүх, соёлын өв бүхий газруудад ариун цэврийн байгууламж, авто зогсоол бүхий отоглох цэг /Улсын хэмжээнд/, төсөвт өртөг 2,325.0 сая төгрөг, 2024 онд санхүүжих дүн 2,325.0 сая төгрөг” гэсэн төсөл арга хэмжээний төсөвт өртөг, санхүүжих дүнг 374.1 сая төгрөгөөр бууруулж, “Аялал жуулчлалын байгаль, түүх, соёлын өв бүхий газруудад ариун цэврийн байгууламж, авто зогсоол бүхий отоглох цэг /Булган аймаг, Рашаант сум, Элсэн тасархай/, төсөвт өртөг 374.1 сая төгрөг, 2024 онд санхүүжих дүн 374.1 сая төгрөг” гэсэн төсөл арга хэмжээ шинээр нэмж тусгах гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 31

Татгалзсан: 20

Бүгд: 51

60.8 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

ХОЁР.БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН БАЙНГЫН ХОРОО

Л.Мөнхбаатар: 1.Улсын Их Хурлын гишүүн Ч.Ундрамын гаргасан, Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн төслийн 2 дугаар хавсралтын XIV.3.10.Соёлын салбарын тоног төхөөрөмж /Улсын хэмжээнд/-ийн зардлыг 200.0 сая төгрөгөөр бууруулж, төсөлд “Сэлэнгэ аймгийн Алтанбулаг сумын музейн засварт 2024 он, 200.0 сая төгрөг” гэж нэмэх гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 34

Татгалзсан: 17
Бүгд: 51
66.7 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

2.Улсын Их Хурлын гишүүн Ч.Ундрамын гаргасан, Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн төслийн 2 дугаар хавсралтын XIV.3.10. Соёлын салбарын тоног төхөөрөмж /Улсын хэмжээнд/-ийн зардлыг 400.0 сая төгрөгөөр бууруулж, төсөлд “Сэлэнгэ аймгийн соёлын салбарын тоног төхөөрөмжид 2024 он, 400.0 сая төгрөг” гэж нэмэх гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 34
Татгалзсан: 17
Бүгд: 51
66.7 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

БУСАД САНАЛ

Л.Мөнхбаатар: 1.Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдоржийн гаргасан, Нэгдсэн төсвийн ерөнхийлөн захирагчдын төсвийн төслийн нийт зарлагын Нийгмийн даатгалын сан, зээлийн хүүгийн төлбөр үйл ажиллагааны орлогоос бүрэн санхүүждэг зардлаас бусад урсгал зардлыг 0.76 хувиар буюу 93,000.0 сая төгрөгөөр бууруулж, 2018-2023 оны хооронд 6 болон 7 жилийн цалингийн дунджаар тэтгэвэрээ тооцуулсан 58.0 мянган иргэний тэтгэврийн нөхөн олговор 93,000.0 сая төгрөгийг Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсөвт тусгах гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж үг хэлэв.

Зөвшөөрсөн: 31
Татгалзсан: 20
Бүгд: 51
60.8 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хурааж дууслаа.

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслүүдийг гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 17 цаг 39 минутад хэлэлцэж дуусав.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

Бусад. Нийслэлийн ерөнхий боловсролын “Шинэ Монгол Харүмафүжи” сургуулийн 9 дүгээр ангийн багш, сурагчид, Улсын Их Хурлын гишүүн Г.Дамдинням, Б.Жавхлан, Б.Баттөмөр нарын урилгаар Дархан-Уул аймгийн Ерөнхий боловсролын “Оюуны ирээдүй” сургуулийн багш нар төлөөлөл Улсын Их Хурлын чуулганы үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцав.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Хуралдаан зохион байгуулах хэлтсийн дарга Н.Наранцогт, мөн хэлтсийн шинжээч Ш.Мөнхцоож, С.Энхзаяа нар хариуцан ажиллав.

Хуралдаан 1 цаг 56 минут үргэлжилж, 72 гишүүнээс 58 гишүүн хүрэлцэн ирж, 80.5 хувийн ирцтэйгээр 17 цаг 40 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ЕРӨНХИЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Л.ӨЛЗИЙСАЙХАН

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ
ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2023 оны 11 дүгээр сарын 08-ны өдөр,
Лхагва гараг
Төрийн ордон “Их хуралдай” танхим
14 цаг 03 минут.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Г.Занданшатар: Улсын Их Хурлын гишүүдийн өдрийн амгаланг айлтгая.

Гишүүдийн ирц бүрдсэн тул Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы 11 дүгээр сарын 08-ны өдрийн нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Нэг.Монгол Улсын 2024 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслүүдийн хоёр дахь хэлэлцүүлгийг явуулна. Зарчмын зөрүүтэй 19 саналтай.

Хоёр.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулна.

Зарчмын зөрүүтэй нэг саналтай байна. Ингээд хэлэлцэх асуудалдаа оръё.

Нэг.Монгол Улсын 2024 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2023.09.29-ний өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг/

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслүүдийн хоёр дахь хэлэлцүүлгийг явуулна.

Төслүүдийг хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн дарга Дуламдоржийн Тогтохсүрэн танилцуулна.

Д.Тогтохсүрэн: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 09 дүгээр сарын 29-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2024 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслийн нэг дэх хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын чуулганы 2023 оны 10 дугаар сарын 19, 20-ны өдрийн нэгдсэн

хуралдаанаар хийж, хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр бүх Байнгын хороод, Төсвийн зарлагын хяналтын дэд хороонд шилжүүлсэн билээ.

Улсын Их Хурлын даргын 2023 оны 162 дугаар захирамжаар төсвийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийг Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэнгээр ахлуулан ажлын хэсгийг байгуулан ажиллуулсан бөгөөд тус ажлын хэсгээс төсвийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх ажлын хүрээнд дэд ажлын хэсгийг байгуулан ажиллуулж, саналуудыг нэгтгэн хэлэлцлээ.

Улсын Их Хурлын бусад Байнгын хороод, Төсвийн зарлагын хяналтын дэд хороо өөрийн эрхлэх асуудлынхаа хүрээнд төсвийн төслийг хэлэлцээд санал тус бүрээр санал хураалт явуулж олонхын дэмжлэг авсан, аваагүйгээр нь бүлэглэн томьёолж, зарчмын зөрүүтэй саналын томьёоллын хамт Төсвийн байнгын хороонд ирүүлсэн.

Төсвийн байнгын хороо 2023 оны 11 дүгээр сарын 08-ны өдрүүдийн хуралдаанаараа төсвийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг хийж, Төсвийн байнгын хорооны гишүүд, түүнчлэн бусад Байнгын хороо, төсвийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгээс гаргасан санал нэг бүрийг хэлэлцэж ил санал хураалт явуулж, олонхын дэмжлэг авсан, аваагүй хэсгээр нь бүлэглэн томьёолж, зарчмын зөрүүтэй саналын томьёолол бэлтгэсэн.

Түүнчлэн Улсын Их Хурлын Тамгын газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсээс төсвийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан төсвийн санал нь Засгийн

газраас өргөн мэдүүлсэн төсвийн зарлагын болон алдагдлын дүнг нэмэгдүүлээгүй байх, Төсвийн тухай хуулийн 6.2.6, 29.3, 29.4-т заасан шаардлагыг хангасан эсэх талаар дүн шинжилгээ хийж, гарсан дүгнэлт зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг нэгдсэн хуралдаанд танилцуулахаар Та бүхэнд тараасан болно.

Төсвийн ажлын хэсэг болон Төсвийн байнгын хорооноос Засгийн газрын өргөн мэдүүлсэн төсвийн төсөлд өөрчлөлт оруулах санал гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно. Үүнд:

1.Төсвийн тэнцэл сайжруулахтай холбогдуулан төсвийн орлогыг 590.8 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж, Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийг 0.8 хувиар сайжрууллаа.

2.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийг нэмэгдүүлэх зорилгоор Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын төсвийн багцын Нийгмийн даатгалын санд олгох татаасыг 140.7 тэрбум төгрөгөөр нэмэгдүүллээ.

3.Улсын төсвийн хөрөнгөөр зайлшгүй хэрэгжүүлэх шаардлагатай зарим хөрөнгө оруулалтыг нэмж тусгах, түүнчлэн 2024 оны төсвийн жилд улсын төсвөөс санхүүжүүлэхээр тусгагдсан хөрөнгө оруулалтыг гүйцээн ашиглалтад оруулах шаардлагыг үндэслэн зарим төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг нэмэгдүүлэх өөрчлөлтийг тусгалаа.

4.Зайлшгүй шаардлагыг үндэслэн 2024 оны санхүүжих дүнд нөлөөлөхгүй төсвийн захирагч нарын багц дотор болон

багц хооронд зохицуулалт хийх зэрэг саналуудыг гаргасан болно.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.9 дэх хэсэгт заасны дагуу Төсвийн байнгын хороо төсвийн төсөлтэй холбогдуулан төсвийн ажлын хэсэг, бусад Байнгын хороо, түүнчлэн Төсвийн байнгын хорооны гишүүдийн гаргасан санал нэг бүрийг хэлэлцэж, ил санал хураалт явуулж олонхын дэмжлэг авсан, аваагүйгээр нь бүлэглэн томъёолж, Та бүхэнд тараасан болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслийг хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар: Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн санал, дүгнэлтийг Ардчилсан намын бүлгийн дарга Улсын Их Хурлын гишүүн Одонгийн Цогтгэрэл танилцуулна. Индэрт урьж байна.

О.Цогтгэрэл: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Дэлхийн улс орнууд цар тахлаас үүдэлтэй эдийн засгийн хямралт нөхцөл байдлыг даван туулахын тулд төсөв

мөнгөний бодлогоо чангаруулан төсвийн зардлаа танаж, алдагдалгүй байлгахад анхаарч байна.

Харин манай улсын хувьд

2023 онд төсвөө өмнөх оноосоо **34 хувь,**

2024 онд дахин **31 хувиар тэлж,** төсвийн зарлагыг 3-хан сарын өмнө баталсан Төсвийн хүрээний мэдэгдлээс даруй **5 их наядар нэмэгдүүллээ.**

Төсвийн дунд хүрээний бодлогын баримт бичгээ

2021 онд 3 удаа,

2022 онд 2 удаа,

2023 онд 2 удаа өөрчилж байгаа нь өнөөгийн Засгийн газар тооцоо судалгаагүй, алсын хараагүй, асуудлаа олж харахгүй байгааг батлан харуулж байна.

Монгол Улсын **нэгдсэн төсвийн зарлага 3-хан жилийн дотор 2 дахин** нэмэгдэнэ.

Ирэх онд **27 их наядад** хүрэхээр байгаа нь эрх баригчид Та бүхний боловсруулсан төсөв бүхэлдээ сонгууль, улс төр лүү чиглэж байгааг харуулж байна.

Ингэж хэт тэлсэн төсвийнхөө алдагдлаа бага харагдуулахын тулд орлогоо хийсвэрээр нэмж, эдийн засгийн макро үзүүлэлтүүдээ өөдрөгөөр төсөөлөхөөс өөр аргагүйд хүрснийг **60 сая тонн нүүрс, зэсийн үнийг 9 мянган ам.америк доллар,** эдийн засгийн өсөлтийг **7 хувь,** дотоодын нийт бүтээгдэхүүнийхээ хэмжээг **75** их наяд

төгрөг зэрэг хөөсөрсөн тоонуудаас харж болно.

Гэтэл гадаад нөхцөл байдал өдөр ирэх тусам муудаж, ялангуяа Хятадын эдийн засгийн өсөлт удааширч байна.

Энэ нь төсвийн гүйцэтгэлд эрсдэл үүсэж, төсөвт тодотгол хийх зайлшгүй нөхцөл байдал үүсгэх нь гарцаагүй.

Ирэх сонгууль руу чиглэсэн амлалт, халамж, үр ашиггүй хөрөнгө оруулалтаар дүүрсэн нь энэ төсвийг иргэд “**үлдэх хүнээр ачаа бүү татуул гэдэг шүү**” хэмээн дүгнэн хэлэлцэж байна.

Төсвийн нийт орлогын 30 хувийг уул уурхайн салбараас бүрддэг улсын төсөвт **2021 онд 3.4 их наяд** төгрөгөөр орлого олохоор тооцож байсан бол **2024 онд 8 их наядыг** уул уурхайн салбараас олох нь.

Ам нээх бүрдээ эдийн засгаа солонгоруулна гэж ярьдаг ч ачир дээрээ улам бүр уул уурхайгаас хараат болгох бодлого төсвөөр дамжуулан хэрэгжиж байна.

Нийгмийн халамжийн сангаар дамжуулж буй мөнгө **2016 оныхоос 9 дахин нэмэгдэж, 2.4 их наяд төгрөг** болж өслөө.

Мөн сонгуулийн өмнөх тэтгэвэр, цалинг дахин нэмэхээ эрх баригчид зарлаж байна.

Энэ бол уурхай дагаж олсон мөнгөө халамж болгон тараах схемээ аанай л бас үргэлжлүүлж буйн жишээ юм.

Энэ бүхнээ эрх баригчид сонгуулийн санал худалдан авах сайхан арга заль хэмээн сэтгэж буй боловч улс орныхоо эдийн засгийг сүйрүүлэх гамшигт шийдвэр болж байгааг хэзээ засах вэ.

Ойрын жилүүдэд тэтгэврийн өрийг тэглээд зогсохгүй тэтгэврийн хэмжээг ч хэд хэдэн удаа нэмсэн.

Гэтэл ийм шийдвэр үнэ хөөрөгдөхөөс өөр нөлөө үзүүлсэнгүй.

Иргэдийн амьдралд ч бодитойгоор наалдсангүй.

Улам бүр ядуурлын түвшин нэмэгдэж байна.

Төсвийн дэмжлэгийг зөвхөн зорилтот бүлэг буюу орлого багатай иргэдэд чиглүүлж чадвал төсвийн тэнцвэргүй байдлыг гааруулахгүйгээр байх өндөр ач холбогдолтой.

Халамжаар ядуурлыг шийдсэн улс дэлхий нийтэд байхгүй гэдгийг бас энд онцлон хэлмээр байна.

2021 онтой харьцуулахад аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, хувь хүний орлогын албан татвар, дотоодын барааны НӨАТ бүгд хоёр дахинаас илүүтэй нэмэгдсэн.

Төсөв төлөхийн хэрээр Төв банк мөнгөний бодлогоо чангаруулж, банкнууд дээр байгаа мөнгийг Төв банк үнэт цаас руугаа татаж байна.

Өнөөдөр татвар хомс, санхүүжилт дунд аж ахуйн нэгж, бизнесүүд амьд үлдэх тэмцэлд өдөр бүр орж байна.

Үүнтэй зэрэгцэн төрийн өмчит аж үйлдвэр, аж ахуйн нэгжүүд салбар бүр лүү салаалан орж зах зээлийг нь булаацалдсаар.

Ийм өндөр ачаалал, дарамт дунд компани, иргэд тэмцэлдэж байхад төсөв даргын гарын үсгээр зарцуулагддаг мөнгө улам ихэссээр.

Хүмүүсийн **“Мөнгийг зарцуулдаг сэтгэл зүйн хандлага”**-ыг нарийвчлан судалсан Нобелийн шагналт эдийн засагчийн **“Зарцуулалтын 4 арга зам”**-ыг тодорхойлсон байдаг.

- Хүн өөрийнхөө мөнгийг өөртөө зарцуулахдаа хүссэн зүйлээ хамгийн сайн үнээр авахын тулд болгоомжтой ханддаг бол
- Хэн нэгний мөнгийг өөртөө зарцуулахдаа үүнийг огт хайхардаггүй гэж үздэг.
- Харин өөрийнхөө мөнгийг хэн нэгэнд зарцуулахдаа нөгөө хүний хүслийг биш өртгийг нь илүү чухалчилдаг.
- Харин хүний мөнгийг хэн нэгэнд зарцуулахад өртөг ч хамаагүй, үнэ цэний алинд ч санаа зовдоггүй гэж тэр эрдэмтэн нь баталж, бас нотолжээ.

Ийм учраас үрчийтлээ хөдөлмөрлөсөн иргэдийн мөнгийг татвар болгон хурааж, төсөв нэрээр үрэлгэн дарга нарын хүслээр шийддэг хэмжээг багасгахын тулд Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн гишүүд улсын төсөв бага байх ёстой л гэж дахин дахин хэлдэг.

Монголын төр хувийн хэвшлийн орон зайг төсвөөр дамжуулан булааж байгаа.

Төсөв бүхнийг шийдэж, төр толгойгоо даахгүй болтлоо данхайсан төрийн өмчит хувалз мэт шигдсэн авлига, хээл хахуулийг гааруулж байна.

Ирэх оны төсөвт Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар худалдан авалтыг хуульчлахаар оруулж ирж байна.

Энэ нь өнөөгийн нийгмийн дургүйцлийг дээд цэгт нь хүргээд буй нүүрсний хулгай, ногоон автобусны асуудлыг хуульчлах гэж байгаагаас ялгаагүй.

Төрийн болон орон нутгийн өмчийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар урт хугацааны стратегийн ач холбогдолтой төсөл хэрэгжүүлэх хүрээнд ажил үйлчилгээг 10 жилээр гэрээ байгуулах боломжийг мөн нээн олгож байна.

Өөрөөр хэлбэл төрийн өмчийн хулгайн асуудал хуулийн хамгаалалтад орох ийм нөхцөл бололцоо бүртгэх гэж байна.

Бизнесийн орчныг эрүүлжүүлж, төрийн өмчит компаниудыг зах зээлийн зарчмаар нь засаглал, менежментийг нь сайжруулах, эрүүлээр хөгжүүлэх боломжийг бүрдүүлж анхаарахын оронд хүчин төгөлдөр үйлчлэлтэй эсэх нь эргэлзээтэй Бүгд Найрамдах Монгол Ард Улсын хуулиар бүрэн эрхт төлөөлөгч гэгчийг томилон захиргааны аргаар оролдож буй нь тун харамсалтай.

Эрдэнэс Тавантолгой, Эрдэнэтээс эхлүүлээд өнгөтэй өөдтэй бүхнийг бүрэн эрхт төлөөлөгч томилно, нууц, хаалттай орчинд шилжүүлэн аргалж байгааг сонгууль угтсан, сонгуульд бэлдсэн мөнгө босголтын схем нь цаанаа л ажиллаж буй юм биш биз ээ гэж ард олон нийт хардахад хүргэж байна.

Төсвийн хөрөнгө оруулалтын хуваарилалт, байршуулалт жигд, эдийн засгийн үр ашигтай, нийгмийн ач холбогдолтой байх зарчим бүрмөсөн алдагдлаа.

Хөрөнгө оруулалтын **1050** арга хэмжээний **80 хувь** нь цаашид төсвийн урсгал зардлыг байнга нэмэгдүүлэхээр байгаа нь бас аюулын дохио юм.

Иймээс хөрөнгө оруулалтын ач холбогдлоор нь эрэмбэлж, ердөө **240** төсвийг л царцаахад **920 тэрбум** төгрөгийн хэмнэлт хийх боломж бидэнд байна.

Та бүхэн олон төсөвтэй байж болохгүй ээ, гадаад өрийг нэмж болохгүй гэж байнга шүүмжилж ирсэн.

Өнөөдөр Монгол Улсын төсөвтэй зэрэгцээд Монголбанк, Хөгжлийн банк, Эрдэнэт, Эрдэнэс Тавантолгой, Эрдэнэс Силвер гэх мэт төрийн өмчит компаниуд төсвийн шинж чанартай санхүүжилтийг тоолбол **бие даасан 10 гаруй төсөвтэй болж**, төсвийн иж бүрэн байдлын зарчим алдагдлаа.

Сүүлийн хоёр сонгуульд дамнан хэт олонх болсон эрх баригчид 2016 оны Улсын Их Хурлын сонгуульд **Монгол Улсын иргэн бүр 15 сая төгрөгийн**

өр ноогдох болсон талаар халаглаж, засаж залруулахаа амлаж байсан.

Гэвч энэ үзүүлэлт одоо 33 сая төгрөгтэй тэнцэж байна.

Ийнхүү Монгол Улсын гадаад өрийн хавханд гүн бат шигдэж гадаад өр Монгол Улсын эдийн засгийн аюулгүй байдлаас салж улс орны тусгаар тогтнолын асуудал болохыг үгүйсгэхгүй.

Эцэс сүүлдээ Та бүхэн хууль дотор үг үсгээр тоглон, **Засгийн газрын өр дотоодын нийт бүтээгдэхүүний 60 хувь дотор багтаж байгаа** хэмээн өгүүлдэг.

Гэтэл Дэлхийн банкнаас төрийн өрийг аль эрт дотоодын нийт бүтээгдэхүүний 100 хувь давсныг анхааруулдаг.

Төрийн оронд Монголбанкны өрийг оруулан тооцохгүй гэх мэтээр төрийн өр, Засгийн газрын өр гэж үгийн тоглоом хийсээр өнөөдрийг хүрлээ.

Монгол төрийн өр дотоодын нийт бүтээгдэхүүнийхээ 100 гаруй хувийг давчхаад байгаа.

Энд дурдсан бүхэн нь өрийн хэмжээг тогтворжуулах, төсвийн алдагдал, өрийн хуримтлалыг бууруулахад чиглэсэн төсвийн бодлогын шинэчлэлтийг нэн даруй эхлүүлэх шаардлага үүссэн гэж Ардчилсан намын бүлэг үздэг.

Төсвийн шинэчлэл хийснээр эдийн засгаа төрөлжүүлж, илүү тогтвортой, уян хатан эдийн засгийг дунд хугацаанд бүрдүүлэх боломж бүрдэнэ.

Төсвийн мөнгөөр байшин бариад ажлын байр бий болдоггүй юм байна.

Халамж тараагаад ядуурал буурдаггүйг ойлгон төсвийн төслийг гоё ганган уриа лоозонгоор чимэглэхэд анхаарах бус, харин өрийн хэмжээ нэмэгдүүлэхгүй, эдийн засгийн бүтцээ засах, эдийн засагт бугшсан алдаа завхрал бүрийг хугацаа алдалгүй шийдвэрлэх нэн шаардлагатай үе бидэнд тулж ирээд байна.

Та бүхэнд амжилт хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

Г.Занданшатар: Одоо Төсвийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан төсвийн саналуудыг холбогдох хуулийн шаардлага хангасан эсэх талаарх Улсын Их Хурлын Тамгын газрын Төсвийн хяналт, шинжилгээний асуудал хариуцсан нэгжийн дүгнэлтийг хэлтсийн дарга Даваасүрэнгийн Эрдэнэсамбуу танилцуулна.

Д.Эрдэнэсамбуу: Улсын Их Хурлын дарга, Эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 09 дүгээр сарын 29-ний өдөр өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2024 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслүүд болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн хоёр дахь хэлэлцүүлгийг 2023 оны 11 дүгээр сарын 07-ны өдөр Төсвийн байнгын хороо хийлээ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай

хуулийн 70 дугаар зүйлийн 70.13-д заасны дагуу төсвийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан санал нь тус хуулийн 70.7.2, 70.7.3-т заасан шаардлагыг хангасан эсэх талаар дүн шинжилгээ хийж, дараах дүгнэлтийг гарган Та бүхэнд танилцуулж байна.

1.Төсвийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан төсвийн орлого нэмэгдүүлэх 2, урсгал зардал нэмэгдүүлэх 13, урсгал зардал бууруулах 2 санал, хөрөнгийн зардал өөрчлөх 7 багц санал болон зарчмын бусад саналууд гарсан.

2.Төсвийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгээр төсвийн орлогыг 565.4 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлснээр нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын хэмжээ **25.855.2 тэрбум** төгрөг, нийт зарлагын хэмжээ **27.360.5 тэрбум** төгрөг болж, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл **1.505.3 тэрбум** төгрөг буюу дотоодын нийт бүтээгдэхүүний **2.0** хувьтай тэнцэх хэмжээний төсвийн алдагдалтай байхаар өөрчлөлт хийгдлээ.

Төсвийн орлого нэмэгдэж, төсвийн тэнцлийг сайжруулсан бөгөөд төсөвт төвлөрүүлэх татварын хэмжээг бууруулаагүй нь Төсвийн тухай хуулийн 6.2.6.б-д заасан **“Төсөвт төвлөрүүлэх татвар болон төлбөрийн хэмжээг бууруулах бол мөн хэмжээгээр зардлыг бууруулах”** гэсэн нөхцөл үүсээгүй.

3.Төсвийн урсгал зардлыг 346.2 тэрбум төгрөгөөр бууруулах, урсгал зардлыг **226.6 тэрбум** төгрөг, хөрөнгө оруулалтын зардлыг **118.8 тэрбум** төгрөгөөр тус тус нэмэгдүүлэх замаар

нэгдсэн төсвийн нийт зарлагын хэмжээг нэмэгдүүлэхгүй байх саналууд гарсан нь Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.7.2-т заасан **“Засгийн газраас өргөн мэдүүлсэн төсвийн төслийн зарлагын болон алдагдлын дүнг нэмэгдүүлэхгүй байх.”** заалт, Төсвийн тухай хуулийн 6.2.6-д заасан **“Тодорхой төсөл, хөтөлбөр, арга хэмжээний зардлыг мөн хэмжээгээр бууруулж, нийт зарлагын хэмжээг нэмэгдүүлэхгүй байх.”** гэсэн шаардлагуудыг хангасан байна.

4. Олонхын дэмжлэг авсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санал нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3.1-29.3.4-т заасан шаардлагыг хангасан, харин **227.5 тэрбум** төгрөгийн санхүүжих дүнтэй **86 төсөл, арга хэмжээ** нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3.5-т заасны дагуу шинээр эхлэх барилга, байгууламж, төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх хугацаанд тэнцүү хуваарилсан хэмжээнээс багагүй байхаар тооцоолох гэсэн зарчимд нийцээгүй байна.

5. Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4 дэх хэсэгт заасны дагуу хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон эсэхийг нягталж үзэхэд **12.9 тэрбум** төгрөгийн санхүүжих дүнтэй **9 төсөл, арга хэмжээ**ний бүрдлийг бүрэн хангуулах арга хэмжээ авах шаардлагатай буюу зураг төсөв нь эцэслэн батлагдаагүй байна.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

Г.Занданшатар: Төсвийн байнгын хорооноос нэгтгэн гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулна.

Нийт 19 санал байгаа юм байна. Гаргасан саналуудыг тайлбарлаж үг хэлж болно.

Зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулна.

Ардчилсан намын бүлгийн дарга Одонгийн Цогтгэрэл гишүүн.

О.Цогтгэрэл: 2024 оны төсвийн хоёр дахь хэлэлцүүлэг явж байна.

Бид бүгд Ардчилсан намын бүлэг дээр байр сууриа нэгтгэж удаа дараа ярилцсан.

2024 оны төсөв асар их тэлэлттэй. Үндсэндээ цалин, тэтгэвэр нэрээр бэлэн мөнгө тараах.

Энэ нь эх үүсвэргүй учраас энэ байтугай хэмжээгээр инфляцыг өдөөх худалдан авах чадварыг улам доройдуулах, тэгээд хувийн хэвшлийг боомилсон, төр нь томорч байгаа учраас хувийн хэвшлийн орон зайг улам боогдуулсан ийм төсөл энэ бүхэнд явж байгаа.

Дагалдаж орж ирсэн хуулиуд дээр бас их олон асуудал бий.

Тэр газрын харилцааг төвлөрүүлсэн. Улаанбаатар хот руу бүгдийг татсан олон асуудал бий.

Тэгэхээр энд бас нэг ноцтой асуудал нь өнгөрсөн хугацаанд гараад нэлээн ололттой зүйл боллоо гэж.

Тэр тусмаа бид бүгд бүрэн дүүрэн дэмжиж явж байсан Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хууль. Төрийн өмчит аж ахуйн нэгжүүд уулзвар уул уурхайн бүтээгдэхүүнийг биржээр арилжина гэсэн хуулийг дагалдаж орж ирсэн хуулиар биржгүйгээр шууд гэрээ хийж болно. Биржгүйгээр шууд гэрээ хийж болно.

Нөгөө талд нь **БЭТ**[*бүтэн эрхт төлөөлөгч*]-тэй.

Энэ бүх харилцаа чинь өөрөө авлигалын асуудал, нүүрсний хулгайн асуудал, ногоон автобус зэргийн асуудлууд дээр гарч байгаа үндэс суурь болсон нь ил тод биш өрсөлдөөнгүй асуудлын цаана юу гардаг билээ.

Энэ бүгдийг хууль ёсны болгож өгөх гэж байгаа ийм нөхцөл байдал энэ төсвийн хууль болоод дагалдах хуулиуд дээр үүсэж байна.

Ийм учраас Ардчилсан намын бүлгийн зүгээс энэ удаагийн 2024 оны төсвийн энэ хоёр дахь хэлэлцүүлэг дээр 2 хоногийн завсарлага авах нь зүйтэй гэж шийдвэрлэсэн.

Энэ асуудлыг шийдвэрлэж өгнө үү.

Г.Занданшатар: Ардчилсан намын бүлгээс завсарлага авах хүсэлт гаргачхав уу? Тийм ээ.

Энэ хуулийн хугацаатай асуудал л даа.

Ер нь хуулийн хугацаатай асуудал энэ тоглоом наргианы асуудал биш.

Их Хурлын нэр хүнд рүү тэгж дайрч Чимэдийн Хүрэлбаатар сайд болохгүй. Сайд нар нь ялангуяа.

Нөгөө талаас хугацаатай асуудал боловч нөгөө талаас үүнийг хоцроож хэлэлцүүлсэн. 19-нөөс хэлэлцэж эхэлсэн.

Эхний долоо хоногос хэлэлцүүлээд явъя гэж зөндөө шаардсан.

Энэ бол Засгийн газрын сайд нарын саналаар ингэж хойшлогдож хэлэлцсэн.

Улсын Их Хурал хойшлуулаад байсан юм байхгүй.

Тийм учраас аль аль талдаа энд хариуцлагатай хандах ёстой.

Ардчилсан намын бүлэгт завсарлага өглөө. М.Оюунчимэг гишүүний саналаар 2 цагийн завсарлага өглөө. /алх цохив/

Зочид танилцуулья.

Нийслэлийн ерөнхий боловсролын “Шинэ Монгол Харүмафүжи” сургуулийн 9 дүгээр ангийн багш, сурагчид парламентын боловсрол хөтөлбөрийн хүрээнд Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Хүндэт сурагчид Та бүхэндээ Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс сурлага, спортын өндөр амжилт хүсэн ерөөе.

Сурах чиглэлийг эрхэм болгож,
улам сайн суралцахыг хүсэн ерөөе.
Хүндэт сурагчдадаа.

Дараагийн асуудлыг чинь шууд
орчхож болно шүү дээ. Тийм ээ.
Холбогдохгүй билүү?

Дараагийн асуудалд орно.

**Хоёр. Монгол Улсын нэгдсэн төсвийн
2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай
хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл
/Засгийн газар 2023.09.29-ний өдөр өргөн мэдүүлсэн,
анхны хэлэлцүүлэг/**

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулна.

Төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн дарга Дуламдоржийн Тогтохсүрэн танилцуулна.

Д.Тогтохсүрэн: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 09 дүгээр сарын 29-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг Улсын Их Хурлын чуулганы 2023 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлсэн.

Төсвийн байнгын хороо 2023 оны 11 дүгээр сарын 07-ны өдрийн хуралдаанаараа дээрх хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлд заасны дагуу явуулж, хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцсэн болно.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед Монгол Улсын төсвийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгээс төсвийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгээр олонхийн дэмжлэг авсан саналуудтай холбогдуулан Эдийн засгийн үндсэн үзүүлэлтэд тусгагдсан Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын хэмжээг **2024 онд “25.289.8”** гэснийг **“25.855.1”** гэж, Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь **2024 онд “34.2”** гэснийг **“34.9”** гэж, Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл **2024 онд “-2.070.8”** гэснийг **“-1.505.4”** гэж, Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь **2024 онд “-2.8”** гэснийг **“-2.0”** гэж, Нэгдсэн төсвийн хөрөнгийн зардлын хэмжээ **2024 онд “6.170.4”** гэснийг **“6.273.3”** гэж, Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь **2024 онд “8.3”** гэснийг **“8.5”** гэж, Нийгмийн халамжийн тухай хуульд заасны дагуу

төсвөөс санхүүжүүлэх зардлын нийт хэмжээ **2024 онд “2.389.6”** гэснийг **“2.351.9”** гэж тус тус өөрчлөх санал гаргасныг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг Та бүхэнд тараасан болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг хийсэн талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар: Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд.

Бөхчулууны Пүрэвдорж гишүүн асуулт асууна.

Б.Пүрэвдорж: Энэ 7 сарын 01-нээс Нийгмийн даатгалын багц хууль хэрэгжиж, батлагдаж ирэх оны 01 сарын 01-нээс хэрэгжиж эхэлнэ.

Тэгэхээр энэ нийгмийн даатгалын багц хуулиар 7 жилийн цалингийн дунджаар тэтгэвэр тогтоосон байсныг буцаагаад 5 жил болгож зөв болгосон.

Энэ хуулийн дагуу 2018-2023 оны хооронд 6 жил болон 7 жилээр жилийн цалингийн дунджаар тэтгэвэрээ бодуулсан тэр хүмүүс 01 сарын 01-нээс тэтгэвэрээ дахин 5 жилээр бодуулж зөв болгох ёстой.

Тэгэхээр энэ хооронд Монгол төрийн буруу бодлогоос болоод **IMF** [International Monetary Fund]-ийн олон улсын валютын шаардлагаас болоод 5 жилийн туршид тэтгэвэрээ 7 жилээр бодуулсан тэр хүмүүс Монгол төрийн буруугаас болж хохирч үлдэх ёсгүй ээ гэж үзэж байгаа.

Тийм ч учраас ахмадууд энэ асуудлыг Та бүхнийг хөдөө орон нутагт ажиллаж байх үед байнга шахаж санал тавьж байгаа.

Тэгэхээр энэ хооронд **нийтдээ 58 мянган ахмадын 93 тэрбум төгрөг буюу нэг хүнд ойролцоогоор сая 600 мянган төгрөгийн нөхөн олговрыг олгох** ийм тооцоолол Нийгмийн даатгалын ерөнхий газрын албан тушаалтнуудын гаргаснаар энэ тооцоолол гарсан байгаа.

Тэгээд энэ 93 тэрбум төгрөгийг сая Нийгмийн даатгалын багц багц хууль батлахдаа нөхөн олговор олгохооргүй заасан байгаа.

Тийм учраас адилхан одоо энэ 2024 оны Нийгмийн даатгалын сангийн төсвийн тухай хууль дээр энэ **93** тэрбум төгрөгийг суурилуулан ахмадуудыг гомдолгүй болгох ийм зайлшгүй шаардлага гарч ирж байна.

Тийм учраас хөшөө дурсгалд мөнгө төгрөг зарцуулж байхын оронд амьд бурхад болсон ахмадууддаа, тэднийг Монгол төрийн буруугаас болж

гомдож байгаа тэр гомдлыг тайлахын үүднээс **58 мянган ахмадуудын 93 тэрбум төгрөгийг 2024 оны төсөв дээр заавал тавьж өг гэж шаардаж байна.** 58 мянган иргэний өмнөөс шаардаж байна.

Хэрвээ энэ төсөв дээр тавихгүй бол орон даяар энэ 58 иргэний гарын үсэг цуглуулах тэр аяныг зохион байгуулна, шаардлага хүргүүлнэ.

Тэгээд болохгүй бол 2024 оны сонгуулиар Ардчилсан нам ялахаар ахмадуудыгаа гомдолгүй болгож өгнө өө.

Г.Занданшатар: Хэнээс асуусан юм? Асуултын цаг шүү дээ.

Хариулах хүн байхгүй юу. Цэвэгдоржийн Туваан гишүүн асуулт асууя.

Ц.Туваан: Төсөв хэлэлцэж байгаа. Үүнтэй холбоотойгоор 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах хэлэлцүүлэг явж байна.

Тэгэхээр төсөв маань 27 их наяд гээд хэмжээний хувьд 2020 онтой харьцуулахад бараг нэг дахин нэмэгдээд явж байгаа.

Тэгэхээр энэ дотор дэвшилттэй нийгмийн, иргэдийн асуудлыг шийдсэн зүйл ч байгаа. Мөн дутагдаж байгаа зайлшгүй хийх ёстой зүйлүүд нь хийгдээгүй зүйлүүд ч байгаа.

Тэгэхээр үүнийг ирэх жилийн төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн төсөөлөл дээр бас тавьж явж байхгүй бол, протоколд оруулж хийж явж байхгүй бол ингээд орхигдоод байна. Жил бүр.

Юу ярьж байна гэхээр хөдөө орон нутагт малчид бүгдээрээ үйлдвэрлэл эрхэлж байгаа. Сая малчдын хөдөлмөр ямар хүнд вэ гэдгийг бүгдээрээ харлаа. Тэд нар дандаа амь насаа дэнчин тавиад малынхаа араас.

Яах вэ, тэр мал бол хувийн өмч. Тэгэхдээ түүнд бэлтгээд өгсөн мах, сүүгээр нь бид худалдаж аваад хүнснийхээ хэрэгцээг хангадаг. Бэлдэж өгсөн ноос, ноолуур, арьс ширээр нь бид хувцас хунар хийгээд өмсдөг.

Тэгэхээр энэ их хүнд хөдөлмөр эрхэлж байгаа хүмүүс байгаа.

Тэгэхээр энэ хүмүүс дээр өөр юм гуйгаагүй. Тэр хүмүүс нэг зүйлийг байнга ярьж байгаа. Тэр нь юу гэхээр бэлдэж өгсөн хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд бүтээгдэхүүнийг бид үүрээд явалтай нь биш дээ.

Үүнийг хүргээд тэр зах зээл рүү нь аваачаад зараад борлуулаад хэдэн цаас болгочихдог ложистик, энэ шийдвэрийг төр гаргаад өгөөч ээ. Үүнтэй холбоотой асуудлыг төсвөөрөө шийдээд өгөөч ээ гэдэг хүсэлтийг бүр толгой дараалан тавьдаг.

Тэгэхээр энэ асуудлыг бид төсөв, төсвийн төсөөлөл, төсвийн хүрээний мэдэгдэл дээрээ ер нь оруулаад шийдээд явахгүй бол байнга орхигдоод байгаа асуудал энэ мөн.

Монгол Улсыг хөдөө аж ахуйн орон, мал аж ахуйн орон гэсэн мөртлөө малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнээ жалга, нүүсэн буурин дээрээ орхиод нүүдэг байдал бүр хэвийн үзэгдэл боллоо.

Тэгэхээр энэ асуудал ер нь яаж тусах юм бэ гэдэг асуултыг асууя.

Хоёрдугаар асуулт нь, бид ирээдүй болсон хүүхдүүддээ гар татах ёсгүй ээ. Хүүхдүүд дээр яагаад ийм юм яригдаж байна гэхээр цэцэрлэгийн хүүхдүүд хоногийн 2475 төгрөгөөр хоол идэж байгаа.

Олны олон, олны нэг шөлтэй хоол хийгээд л болгоод яваад байгаа болохоос биш тэр хүмүүсийн норм, стандартаар хүнсний авах ёстой калорилог хэмжээгээр нь ярих юм бол 2475 төгрөгөөр одоо юу авах юм бэ?

Нэг ширхэг хуушуур аваад дээр нь нэг сүүтэй цай авахад 25 төгрөг дутах ийм мөнгө шүү дээ.

Тэгэхээр энэ мөнгийг яагаад оруулахгүй байна, энэ мөнгийг яагаад тавихгүй байна. Үдийн хоол 1500. 1500 төгрөгийн хоолоор ямар калорилаг, ямар стандарт хангасан хоол идэх вэ?

Хоёрдугаарт, дотуур байрны хүүхдүүдийн мөнгө, хоолны мөнгө 4 мянган төгрөг. 12 дугаар ангийн дотуур байранд байрлаж байгаа хүүхэд өдөрт 5 удаа хүнсний хэрэгцээ авч байгаа. Өглөөний цай, өдрийн цай, хоол гээд.

Үүнд 4 мянган төгрөгт та хэд ер нь юу ирдэг гэж бодож байна? Энэ бол маш хүнд асуудал.

Тэгэхээр энэ асуудлууд яагаад энэ жилийн төсөвт туссангүй вэ?

Тэгээд ирэх жилийнх дээр бодлогоо яаж явуулах юм? Энэ бодлого

чинь ерөөсөө төрийн бодлогын гадна үлдчихээд байна шүү дээ.

Тэгээд бид мэдсээр байж мэдээгүй царайлаад нүдэн балай, чихэн дүлий энэ асуудлын хажуугаар яваад байх юм уу? Хэзээ хүртэл явах юм бэ гэдэг ийм хоёр асуултыг асууя.

Г.Занданшатар: Хэнээс асуусан. Ажлын хэсэг. Дуламдоржийн Тогтохсүрэн дарга хариулья.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асууж байгаа учраас.

Д.Тогтохсүрэн: Мал аж ахуйн түүхий эд, бүтээгдэхүүнд өгдөг урамшууллын хэмжээ хэвээрээ тавигдсан байна лээ.

Харин сарлагийн хөөврийн урамшуулал мөнгө нь тавигдсан мөртлөө шийдвэр нь орж ирээгүй байсан.

Тийм учраас ажлын хэсэг ярилцаж байгаад Байнгын хорооноос шийдвэр гаргаж өмнөх гаргасан Улсын Их Хурлын тогтоолд өөрчлөлт оруулах ийм тогтоолын төслийг санаачлаад явж байгаа.

Энэ долоо хоногт гурав дахь хэлэлцүүлэг өгөөд орж ирж шийдэгдэнэ.

Цэцэрлэгийн хүүхдийн тухайд нийт цэцэрлэгийн болон ерөнхий боловсролын сургуулийн хүүхдийн хоолны мөнгөтэй холбоотой асуудлаар Л.Энх-Амгалан сайд бас их олон хувилбаруудыг сонгож ажилласан. Бид ажлын хэсэгтээ.

500 тэрбум төгрөгийн эх үүсвэр шаардлагатай байгаа юм. Нийт дүнгээрээ. Тэгээд энэ их өндөр дүн байгаа юм.

Ер нь зүгээр миний хувийн бодол бол цаашдаа энэ цэцэрлэгийн хүүхдүүдийн хоолны мөнгөн дээр эцэг, эхээс 50 хувь гаргадаг энэ жишиг рүү явахаас өөр үг байхгүй байх. Эцэг, эхийн оролцоог бий болгох хэрэгтэй байх л гэж би боддог юм.

Яг орж ирсэн асуудалтайгаа холбогдуулаад Сангийн яам тодруулга нэмэлт байвал өгөх байх.

Г.Занданшатар: Энэ анхны хэлэлцүүлэг явагдаж байгаа. Санал, дүгнэлттэй холбогдуулж Төсвийн байнгын хорооноос асууна. Нэг бол Г.Тэмүүлэн дарга хариулах юм уу? Ганзоригийн Тэмүүлэн дарга нэмж хариулж болно.

Г.Тэмүүлэн: Ц.Туваан гишүүний асуултад хариулъя.

Тэгэхээр нэмж тодруулга мэдээлэл өгөхөд яах вэ, хөдөө аж ахуйн гаралтай малын түүхий эд болоод түүний үнэлэмжтэй холбоотой асуудал бас энэ гол бодлогын асуудал байх ёстой.

Засгийн газрын зүгээс, тэр дундаа Хөдөө аж ахуйн яамны зүгээс малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний үнэлэмжийг нэмэгдүүлэх, тэр дундаа үйлдвэрлэлийг дэмжих үүднээс тодорхой дотаци, урамшууллын асуудлыг бодлогоор оруулж ирсэн.

Энэ төсөв дээр бүрэн суусан.

Цаашид хонины ноос болоод сарлагийн хөөвөр, торгон ноос дээр

Улсын Их Хурлын холбогдох хууль тогтоомж, журмын хүрээнд урамшуулал олгогдох асуудлууд яригдаж байгаа.

Ер нь яах вэ, үүнийг манайхан өрөөсгөл, нэг талаас хараад байдаг. Бид мал аж ахуйн салбарыг дэмжихийн тулд, нөгөө талдаа үйлдвэрлэлийг дэмжихийн тулд төрөөс стратегийн бүтээгдэхүүн болсон бодлогын асуудлууд дээр урамшууллын тогтолцоог бий болгох зайлшгүй шаардлага байгаа.

Тэгэхээр энэ бодлогууд төсөв дээр суусан. Засгийн газраас орж ирсэн. Бид хууль тогтоомжийн хүрээнд хийгдэх ёстой өөрчлөлтүүдийг Улсын Их Хурал дээрээс, Байнгын хорооноос хийгээд явж байгаа гэдэг зүйлийг хэлэх байна.

Хүүхдийн хоолтой холбоотой. Хөдөө орон нутагт, тэр дундаа цэцэрлэгийн хүүхдийн хоол болоод, сургуулийн хүүхдийн үдийн хоол, дотуур байрны хоногийн хоолны мөнгө нэг талдаа хүрэлцээгүй.

Засгийн газраас төсвийн төсөл дээр ямар нэг байдлаар нэмэгдүүлсэн байдлаар оруулж ирээгүй байгаа.

Тодруулга, мэдээллийг бид авч үзсэн.

Ер нь цаашдаа цэцэрлэг дээр эцэг, эхчүүдтэй хуваалцана гэдэг юм уу, эсвэл зөвхөн дотуур байр, ерөнхий боловсролын сургуулиуд дээр гээд аваад үзэхэд бид хамгийн бага хувилбараар доод тал нь 100 орчим тэрбум төгрөгийн асуудлыг шийдвэрлэх шаардлагатай байгаа.

Энд дотуур байранд гэхэд нийтдээ 30 гаруй мянган хүүхдийн санхүүжилт,

зардлын асуудлыг зайлшгүй шийдвэрлэх шаардлагатай.

Тэгэхээр ер нь үүнийг бас яг Засгийн газрын зүгээс бодлогоор тодорхой энэ 3 үдийн хоолтой холбоотой, дотуур байрны санхүүжилттэй холбоотой, цэцэрлэгтэй холбоотой асуудлууд дээр тодорхой бодлогоо гаргаад, санхүүжилтийнх нь бодлогыг төлөвлөгөөтэй нь гаргаж ирээд оруулж ирэх зайлшгүй шаардлагатай гэж харж байгаа.

Ерөнхий мэдээллүүдийг танд хэлэхэд нийтдээ бага ангийн 38 мянган хүүхдүүд байгаа.

7500 төгрөг болгоод тооцоод үзэхэд 72.3 тэрбум төгрөгийн санхүүжилттэй.

Цаашдаа нэмэгдэх байдлаар төсөв нь 42.9 тэрбум гэсэн тооцоолол дүнг бид гаргаж ирсэн.

Дотуур байрны 38 мянган хүүхдийн хоолны нэмэгдэл зардалд нийтдээ 42.0 тэрбум төгрөг. Энэ дээрээ нэмэх нь ерөнхий боловсролын 1-ээс 5 дугаар ангийн хүүхдүүд хоолны нэмэгдэл гээд аваад үзэхээр 117.0 тэрбум төгрөг гэдэг юм уу.

Ер нь хэд хэдэн хувилбаруудаар асуудлыг судалж үзсэн.

Ингээд ажлын хэсэг энэ асуудал дээр тодорхой бодлого, санал, шийдлийг гаргаж ирээгүй.

Бид одоогийн байдлаар Засгийн газраас өргөн баригдсан төслөөр нь энэ төсвийн төслийг явуулж байгаа. Тэгэхдээ яаралтай Засгийн газар цэцэрлэг,

сургуулийн дотуур байрны хүүхдийн хоолтой холбоотой асуудлуудаар тодорхой бодлогын шийдлийг гаргаж оруулж ирэх ёстой гэж харж байгаа.

Г.Занданшатар: Одоо Баагаагийн Баттөмөр гишүүн асуулт асууна.

Б.Баттөмөр: Бид 2023 оны 5 сарын 31-нд буюу 6 сарын 01-нд Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуулийг баталсан.

Энэ хуульд төсвийн орлогыг 21.1 их наяд төгрөг гэж баталж өгсөн. Гэтэл бол сая орж ирж байгаа нь бол 25.2 гээд 4.1 их наяд төгрөгөөр нэмэгдэж орж ирж байна.

Төсвийн зарлагын хэмжээг 22.9 их наяд гэсэн 27.3 гээд 4.3 их наяд төгрөгөөр.

Төсвийн өсөлт, зарлагын өсөлтийн хэмжээг 2.5 их наяд гэсэн. 5 их наяд гэж орж ирж байгаа юм.

Энэ хуулийг хэлэлцэж төсвийн хүрээний мэдэгдлийг баталж байх үед миний бие тэр хэлэлцүүлгийн нэг, хоёр дахь шатад маш тодорхой хэлсэн.

Монгол Улсын хөгжлийн потенциал асар өндөр. Ингэж гутранги харж болохгүй ээ гэж. Маш олон удаа. Одоо протокол байгаа шүү.

Гэтэл 4 сарын дараа ингээд л орж ирж байгаа байхгүй юу.

Уг нь анхнаасаа энэ боломжуудыг зөв хараад, энэ зарлагуудаа зөв эрэмбэлсэн үүнээс илүү үр ашигтай төсөл

батлах л байсан юм. Бүр аргаа ядаад энэ гутранги хүмүүсээр тоо бүү бодуулаач гэж хүртэл хэлсэн шүү дээ.

Тэгээд л батлаад л хаясан. Тэгээд л ингээд л орж ирж байна.

Бидний ажлын гүйцэтгэл ийм л байдалтай байгаа шүү дээ.

Надад бол асуулт алга. Дараа дараагийн энэ төсвийн хүрээнийхээ мэдэгдэл, энэ төлөвлөлтүүдээ сайжруулах шаардлагатай шүү.

Ингэж 4, 5 нь их наядараа зөрүүтэй юм оруулж ирж болохгүй шүү дээ.

Г.Занданшатар: Гишүүд асуулт асууж, хариулж дууслаа. /алх цохив/

Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулна.

Сайд нар суудалдаа суугаарай. Зарчмын зөрүүтэй нэг саналаар санал хураалт явуулна. /алх цохив/

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол.

Төсвийн байнгын хороо дэмжсэн санал байна.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын хэмжээ /тэрбум төгрөг/ 2024 онд “25.289.8” гэснийг “25.855.1” гэж, Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь

2024 онд “34.2” гэснийг “34.9” гэж, Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл /тэрбум төгрөг/ 2024 онд “-2.070.8” гэснийг “-1.505.4” гэж, Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь 2024 онд “-2.8” гэснийг “-2.0” гэж, Нэгдсэн төсвийн хөрөнгийн зардлын хэмжээ 2024 онд “6.170.4” гэснийг “6.273.3” гэж, Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь 2024 онд “8.3” гэснийг “8.5” гэж, Нийгмийн халамжийн тухай хуульд заасны дагуу төсвөөс санхүүжүүлэх зардлын нийт хэмжээ /тэрбум төгрөг/ 2024 онд “2.389.6” гэснийг “2.351.9” гэж тус тус өөрчлөх.

Санал гаргасан Ажлын хэсэг. Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн, Ш.Адъяаа, П.Анужин, Т.Аубакир, Э.Бат-Амгалан, Ж.Батсуурь, Б.Баярсайхан, Г.Дамдинням, М.Оюунчимэг, Б.Пүрэвдорж, Ц.Сэргэлэн, Ц.Туваан, Г.Тэмүүлэн, Д.Цогтбаатар, Ц.Цэрэнпунцаг. Н.Энхболд, Ж.Эрдэнэбат.

Санал хураалт. /алх цохив/

70.9 хувиар дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хурааж дууслаа. /алх цохив/

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлээ.

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдааныг завсарлагын

хугацаа дуустал өөр хэлэлцэх асуудалгүй тул завсарлууллаа. /алх цохив/

Энэ чинь 15.00 цаг уу? 14.30-д завсарлага авсан уу? 16.30-д чуулганы нэгдсэн хуралдааныг үргэлжлүүлнэ.

З А В С А Р Л А Г А

Өдрийн амгаланг айлтгая.
Хэлэлцэх асуудалдаа орно.

Ардчилсан намын бүлэг
завсарлага авсан байгаа.

Тэгээд гишүүдийг цуглуулъя.
Ардын намын бүлгийн дарга, холбогдох дарга цуглуулъя.

Тэгээд энэ цуглаж байх хооронд бас нэг зүйлийг хэлэх нь зүйтэй гэж бодож байна.

Өнгөрсөн 7 хоногт буюу 11 дүгээр сарын 03-аас 05-ны өдрүүдэд Монгол Улсын ихэнх нутгийг хамарсан цас орж, цасан шуурга болж, цаг агаарын аюултай үзэгдэл боллоо.

Энэ үеэр хөдөө орон нутгийн зам хаагдаж, авто тээврийн нөхцөл, байдал ноцтой хүндэрч, халтиргаа гулгаа нэмэгдэж, тээвэрлэлт хүндэрснээс гадна хамгийн гол нь хөдөөгийн малчдын амь нас, амьжиргаанд ихээхэн хохирол, гамшиг учрууллаа.

Тэгээд энэ өдрүүдэд 20 хүртэл метр секунд хурдтай цасан шуурга 12-оос 15 цаг хүртэл үргэлжилсэн байна.

Ингэж шуурсны улмаас 12 аймгийн 24 сумд 30 тохиолдлоор нийт 46 хүн сураггүй алга болсон байна.

Тэгээд онцгой байдлын болон орон нутгийн төр захиргааны байгууллагын ажилтнууд эрэн хайх ажиллагааг шуурхай зохион байгуулсны үр дүнд 37 хүнийг эсэн мэнд олсон байна.

Тэгээд харамсалтай нь 8 иргэн, түүний дотор 6 эмэгтэй, 1 хүүхэд, 1 эрэгтэй хүн амь насаа алдсан байна.

Тэдний 5 эмэгтэй, 1 хүүхэд нь Төв аймгийн Эрдэнэ сумын, 1 эмэгтэй нь Төв аймгийн Лүн сумын, өөр 1 эрэгтэй нь Өвөрхангай аймгийн Зүүнбаян-Улаан сумын харьяат иргэд байна.

Тэгээд цаг агаарын аюулт үзэгдлийн улмаас амь насаа алдсан иргэдийнхээ ар гэр, төрөл төрөгсдөд Монгол Улсын Их Хурлын нэрийн өмнөөс болон хувиасаа гүн эмгэнэл илэрхийлье.

Цаг агаарын байгууллагаас ирүүлж байгаа мэдээллээр өнөөдрөөс эхлээд 10-ыг хүртэл хугацаанд нийт нутгаар дахин цас орж, зарим газраар 15-аас 17 метр секунд хурдтай цасан болон шороон шуурга шуурч, хүйтний эрч шөнөдөө 19-өөс 24 градус хүрч болзошгүй байна.

Тэгээд ийм учраас одоо хөдөө орон нутагт зорчиж байгаа иргэд маань, гишүүд та бүхэн ч гэсэн, нутгийн захиргааны байгууллагууд, үүрэг

хүлээсэн албан хаагчид энэ болзошгүй аюул эрсдэлээс урьдчилан сэргийлэх талаар бүхий л талын арга хэмжээг шуурхай оновчтой авч хэрэгжүүлэх хэрэгтэй байна.

Иргэд, малчдад анхааруулах сэрэмжлэгийг цаг алдалгүй хүргэх, Гамшгаас хамгаалах албаныхан хүч хэрэгслийн бэлэн байдлыг сайтар хангах нь чухал байгааг анхааруулж хэлье.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулж Ардчилсан намын бүлэг завсарлага авсан.

Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд заасны дагуу Ардчилсан намын бүлэг завсарлагын хугацаа дууссан байна.

Одонгийн Цогтгэрэл дарга завсарлагатай холбогдуулж үг хэлэх үү? Одонгийн Цогтгэрэл гишүүн, Ардчилсан намын бүлгийн дарга.

О.Цогтгэрэл: 2024 оны төсвийг өргөн баригдахаас эхлээд Ардчилсан намын бүлгийн зүгээс тодорхой байр суурь илэрхийлсээр ирсэн.

2024 оны төсвийг харахад уул уурхайн орлого, үүнийг дагасан улсын төсвийн асар их тэлэлт, үүнийг дагасан улам их халамж.

Ерөөсөө л нэг ийм цикл л явж байгаа. Уул уурхайгаас орлого олно. Төсөв нь улам их томорно. Халамж нь улам их болно.

Гэтэл тэр уул уурхайн орлого хэсэг чинь үнэхээр тийм бодитой юм уу? Тийм эрэлт ббайна уу? Тэр худалдан авагчийн чинь нөхцөл байдал, эрүүл мэнд

нь ямар байна вэ? Үүнийг бүгдээрээ эдийн засаг бас гадарладаг хүмүүс санаа зовнингүй бүгдээрээ харж байна.

Гэтэл энэ бүгд хамаагүй ээ. 2024 оны сонгууль чухал аа. Сонгуулийн бараг урд талын өдөр цалин, тэтгэврийг нэмнэ. Нэг ийм л утга учир бүхий төсөв орж ирээд одоо ингээд бараг боогдоод, баглагдаад явж байна.

Гэтэл энэ төсвөөр бид тулгамдсан ямар ямар их олон асуудлууд байгаа билээ. Эрчим хүч маань ямар байдалтай байгаа билээ. Эрүүл мэндийн даатгал Нийгмийн даатгалаас эхлээд ямар олон асуудал хуримтлагдчихсан байгаа билээ.

Төсөвт энэ их асар их хэмжээний мөнгөнд ямарваа нэгэн эдийн засгийг эрүүлжүүлэх бодлогын нэг ч шийдэл байхгүй. Бодлогын нэг ч шийдэл байхгүй. Улс орон даяар хэрхэн тараан байршуулах вэ, хэрхэн болсон болоогүй төслүүдийг сонгуульд зориулах уу гэдэг ийм л нөхцөл байдалтай.

Харин энэ өдрүүдэд Улсын Их Хурлын даргаас гарч байгаа харин эсрэгээрээ татварыг бууруулья гэдэг энэ бодлогын шийдэл бол үнэхээр. Бид бүгд сөрөг хүчин гээд бүх зүйлийг эсэргүүцэж яваагүй. Улсын Их Хурлын даргаас гаргасан тэр татвар бууруулья. Тэр тусмаа НӨАТ-ын татварыг бууруулья гэдэг санаачилгыг бид бүгд анхнаас нь хоёр гараа өргөөд л дэмжсэн.

Энэ бол маш зөв зүйтэй шийдэл байна. Энэ тэтгэвэр нэмж байна, цалин нэмж байна гэххээд нөгөө талд нь инфляцыг өдөөх биш, тэр худалдан авалтынх нь өртөг, зардлыг нь бууруулья, бодит орлогыг нь бууруулья. Энэ бас эдийн засгийг эрүүлжүүлэх, далд эдийн

засгийг ил гаргах, үнэхээр энэ бол бас дэмжүүштэй гэж сөрөг хүчний зүгээс Улсын Их Хурлын даргаас гарч байгаа санаачилгыг бид хоёр гараа өргөөд дэмжсэн.

Ямарваа хоёргүй утгаар бид дэмжээд л явсан. Хэрвээ энэ бодлого тодорхой хэмжээгээр суугаад орж ирсэн бол, энд бид засвар өөрчлөлтийг хийсэн бол энэ төсөв үнэхээр ахиц дэвшилтэй сайн чиг рүү хандсан нь энэ чиглэлд явах байлаа.

Монгол Улсын төсөв өсөн нэмэгдсээр байгаад одоо бараг дотоодын нийт эдийн засгийнхаа 40 хувь руу ойртож байна. Төрийн өмчит компанийг нэмбэл 60, 70 хувь болж байна.

Одоо бид яг ямар нийгэм байгуулаад байгаа билээ. Бид тэр социализм, коммунизм байгуулж байгаа коммунист төртэй Хятад Улсын төсөв нь өнөөдөр эдийн засагтаа 25.5 хувийг эзэлдэг юм гэнэ лээ.

Гэтэл зах зээлийн эдийн засгийг байгуулж байгаа хувийн хэвшилд тулгуурлана гэж лоозон болгосон Монгол Улс 40 хувь.

Тэгэхээр татвар, зөвхөн НӨАТ биш бүхий л татварыг бууруулах ёстой гэдэг байр суурийг бид бүгд байнга илэрхийлдэг.

Ийм учраас энэ удаагийн төсвийн энэ бүх үйл явцад, бодлогын хувьд эсрэг зүгт явж байгаа гэдэг байр суурьтай байгаагаа Ардчилсан намын бүлгийн зүгээс дахин илэрхийлье.

Тэгээд Улсын Их Хурлын даргад хандаж дэгийн тухай хуулийн дагуу

завсарлагааны хугацаа, хуулийн хугацаанд сунгаж өгөхийг хүсье.

Г.Занданшатар: Юуны өмнө зөвхөн Улсын Их Хурлын даргын гаргасан ч санал биш.

Энэ **D-Parliament** аппликэйшнд 405 өргөдөл ирсэн байгаа. Бүх хүмүүсийн ярихыг харж үзэж болно.

405 өргөдлийн 205 өргөдөл нь нэмэгдсэн өртгийн албан татварыг бууруулах, урамшууллыг нэмэгдүүлэхтэй холбоотой санал байсан.

Хоёрдугаарт нь, үүнийг Худалдаа, аж үйлдвэрийн танхим, бизнесийн байгууллагуудаас хэлэлцээд тодорхой санал, төлөвлөгөөтэй ирүүлсэн.

Тэгээд аль нэгийнх нь нэрээр тавьж болохгүй байгаа учраас иргэдийнхээ саналыг хүндэтгэлтэй хандаж байршуулаад 100 мянган хүний санал дэмжигдсэн. Үүнийг Төсвийн байнгын хороо, төсвийн ажлын хэсэгт шилжүүлсэн.

Тэндээ хэлэлцээд шийдвэр гаргана гэдэгт итгэж байна.

Завсарлагын хувьд хугацаатай асуудал учраас Ардчилсан намын бүлгийн даргыг энэ асуудлыг ойлгож хүлээж аваад, тэгээд хэлэлцүүлгийн үед санал бодлоо хэлээд, ингээд бид цаг хугацаа, минутыг нь өгнө. Энэ дээр ч яриад яваад байж болно.

Тэгээд парламентаар хэлэлцээд явъя гэсэн ийм саналтай байна.

Одоо бол бидний мэдлээс гарсан. Цэвэр төсвийн ажлын хэсэг, Төсвийн

байнгын хороонд шилжүүлсэн. Тэд нар шийдвэр гарна. Одоо энэ ард түмний саналыг яах юм, ямар шийдвэр, судалгаа гаргах юм.

Ер нь импортын татварыг хэт бага байна. Нэн ялангуяа тансаг хэрэглээ, үнэтэй хэрэглээ, хэт өндөр орлоготой иргэдийг дэмжсэн. Нийт ард түмэндээ амраар нь НӨАТ дээрээ ачаагаа хуваалцсан.

Тэгээд татвар төлдөг, төлдөггүй, НӨАТ-ын баримт өгдөг, өгдөггүй гээд маш их асуудал амьдралд байгаа учраас л, энэ амьдралаас ургаж гарч ирсэн асуудал.

Ард түмэн олон мянгаар үүнийг илэрхийлж байгаа учраас зайлшгүй

хэлэлцэж шийдвэрлэх ёстой асуудал гэж үзэж байгаа.

Үүнийг тэгээд татварын реформын хүрээнд Төсвийн байнгын хороо, төсвийн ажлын хэсэг шийдвэрлэж тодорхой шийдвэр гарна гэдэгт итгэж байна.

Ингээд О.Цогтгэрэл дарга аа, тэгээд хэлэлцээд явчихъя. Тэгэх үү? Та хэлэлцүүлэг дээр юмаа яриад, тодорхой саналууд дээр саналаа яриад явчихвал сайн байна. Тэгэх үү?

Тэгвэл хэлэлцүүлэгтээ орьё оо.
/алх цохив/

Завсарлагын хугацаа дууссан тул одоо хэлэлцүүлгийг үргэлжлүүлэн явуулна.

**Нэг.Монгол Улсын 2024 оны төсвийн тухай,
Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай,
Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслүүд
/Засгийн газар 2023.09.29-ний өдөр өргөн мэдүүлсэн,
хоёр дахь хэлэлцүүлэг, үргэлжлэл/**

Төсвийн байнгын хорооны нэгтгэн гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураана.

Нийт 19 санал байгаа.

Гаргасан саналуудыг тайлбарлаж үг хэлж болно.

**НЭГ.ТӨСВИЙН ТЭНЦЭЛ
САЙЖРУУЛАХТАЙ ХОЛБООТОЙ
ТӨСВИЙН ОРЛОГО НЭМЭГДҮҮЛЭХ
САНАЛ:**

1.Төсвийн орлого нэмэгдүүлэх санал:

Дүн: 590,761.3 сая төгрөг

1.1.Олон жил хуримтлагдсан татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн төлбөрийн өрийг үе шаттай барагдуулж, төсвийн тогтвортой байдлыг хангах, иргэдийн цалин, тэтгэвэр, тэтгэмж, төрийн үйлчилгээний зардлын санхүүжилтийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах зорилгоор аж ахуйн нэгжийн орлогын албан татварын 2022 оноос өмнөх хуримтлагдсан өр төлбөрийг 20-иос доошгүй хувь буюу **92,100.0 сая** төгрөгөөр, нэмэгдсэн өртгийн албан татварын хуримтлагдсан өр төлбөрийг 20-иос доошгүй хувь буюу **194,300.0 сая** төгрөгөөр, нийгмийн

даатгалын шимтгэлийн хуримтлагдсан өр төлбөрийг 50-иас доошгүй хувь буюу **256,361.3** сая төгрөгөөр тус тус барагдуулж, улсын төсвийн орлогыг **542,761.3 сая** төгрөгөөр нэмэгдүүлэх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн, Ш.Адьяа, П.Анужин, Т.Аубакир, Э.Бат-Амгалан, Ж.Батсуурь, Б.Баярсайхан, Г.Дамдинням, М.Оюунчимэг, Б.Пүрэвдорж, Ц.Сэргэлэн, Ц.Туваан, Г.Тэмүүлэн, Д.Цогтбаатар, Ц.Цэрэнпунцаг, Н.Энхболд, Ж.Эрдэнэбат. Цаашид “Ажлын хэсэг” гэнэ.

Асуулт байхгүй. Санал хэлж болно. Бөхчулууны Пүрэвдорж гишүүн.

Б.Пүрэвдорж: Би яг энэ асуудал дээр эсрэг санал өгсөн. Тэгээд яагаад эсрэг санал өгснөө бас тайлбарлаж хэлэх нь зүйтэй.

Тэгэхээр КОВИД-ын үеийн хямрал, ялангуяа бизнест учирсан гол асуудал бол тээвэр, ложистикийн хямрал л байгаад байгаа юм.

Энэ хямралтай холбоотойгоор маш их тийм өр компаниудад бий болсон. Тэгээд түүнээсээ өнөөдрийг хүртэл ерөөсөө гарч чадахгүй байгаа. Юун өр төлбөр төлөх. Ажилтнаа яаж хадгалж үлдэх вэ, цалингаа яаж тавих вэ. Үүнийг зорьж яваа тэр компаниудад энэ маш том дарамт болж очно.

Энд хууль болоод оччихдог. Хууль болоод очихоор ямар асуудал гарах вэ гэхээр татварын байгууллага нөгөө хэдэн аж ахуйн нэгжүүдийг чинь өдөр шөнөгүй дуудаад л, дарамтлаад л, дансыг нь хаагаад л бүх зүйл дээр хамгийн хатуу харгис хандаж эхэлнэ. Тэр

үед чинь бизнесийнхэн бүгдээрээ дургүйцнэ.

Тэгэхээр өнөөдөр энэ хүмүүсээс өр төлбөрийг нь нэхэх байтугай тийм ээ, тодорхой хугацаагаар нь өрийг нь хойшлуулах ийм шийдвэр гаргаад.

Тэгэхдээ заавал төлүүлэхээр ийм юу байдаг юм 5 жилээр өр төлбөрийг нь хойшлуулаад 20, 20 хувиар төлүүлэх замаар аж ахуйн нэгжүүддээ боломж олгох нь илүү.

Одоо энэ КОВИД-оос гараад компаниуд дөнгөж өндийх гэж байгаа энэ үед нь дэмжлэг үзүүлэх нь хамгийн чухал байгаа юм.

Тэгэхээр бид өрөө цуглуулна гээд шийдвэр гаргана. Хүмүүст сайхан сонсогдож байж магадгүй.

Тэгэхдээ яг тэр үүрэг гүйцэтгэж байгаа тэр татварын байгууллагынхан, нийгмийн даатгалынхан, тэгээд өөр юу байдаг юм, бүх албан хаагч нар дээр чинь энэ төсөв бүрдүүлэх дарамт чинь бүгд очно.

Тэр төрийн албан хаагч нарт чинь ажлын хариуцлага ярина. Ажлын хариуцлага ярихаар тэр хүмүүс чинь хаашаа очих вэ гэхээр нөгөө аж ахуйн нэгж дээр очиж дарамтална, дансыг нь хаалгана.

Үүнээсээ болоод одоо энэ чинь тэр урдах аж ахуйгаа яая гэж байгаа тэр хүмүүс чинь бөөн стресст ороод, бөөн асуудал үүсэх байхгүй юу даа.

Тийм учраас энэ дээр ялангуяа зүгээр шууд төлбөрийг барагдуулах замаар нэмэгдүүлнэ гэдэг заалтынхаа

дотор яг тэр аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааг тодорхой үнэлж дүгнээд ямар асуудалтай байна, юу байна, өрөө төлөх ямар боломж байна тэр зүйлийг бас тодорхой энэ дотор нь заалт оруулж өгч тусгахгүй болбол наадах чинь шууд хэрэгжилтээрээ очоод л нэг хүн дарамталдаг хэрэгсэл болж хувирна л гэж би хараад байгаа юм.

Тийм учраас энэ дээр тодорхой хэмжээний дагасан нэг заалт оруулах хэрэгтэй байна.

Бас тодорхой одоо тэр аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааг дэмжих ямар боломжууд байна. Дэмжингээ өрөө төлүүлэх ямар боломж байна.

Тэр зүйлийг оруулж өгөхгүй бол төрийн албан хаагч нар дээр чинь энэ чинь тэгээд шууд шийдвэр болоод очно шүү гэдгийг л хэлье.

Одоо аж ахуйн нэгжүүдээ жоохон хамгаалах хэрэгтэй байна. Өөд нь татах хэрэгтэй байна. Тэгж байж бид эдийн засгаа аврах, эдийн засгаа солонгоруулах тэр бүх зүйл рүү явна.

Хэрвээ аж ахуйн нэгжээ дарамтлаад байвал тэр аж ахуйн нэгжүүд чинь үүд хаалгаа бариад баахан ажилгүй хүмүүс гарч ирнэ.

Энэ улс чинь зөвхөн нүүрс дээр, уул уурхайн бүтээгдэхүүний экспорт дээр тогтдог ийм л улс орон болж хувирна. Тэр уул уурхайн орлого чинь хэдхэн хүнд очиж байгаа.

Гэтэл одоо хөдөө аж ахуйн салбарт гэхэд 500 мянган хүн ажиллаж байгаа шүү дээ.

Жижиг, дунд үйлдвэрлэлийн салбарт өчнөөн олон зуун мянгаар хүн ажиллаж байна. Амьдралаа аваад явж байна. Тэр хүмүүс чинь арай гэж байхад нь буцаагаад дарамтлаад байж болохгүй байна.

Тийм учраас энэ дээр тодорхой чиглэл Их Хурлын даргын зүгээс өгөөч ээ гэж хүсэж байна.

Г.Занданшатар: Дэмжихгүй санал хэллээ. Санал хураалт явуулъя. Одоо нэмэх бололцоогүй л дээ. Санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

69.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

1.2.Ирээдүйн өв сангийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1 дэх заалтад зааснаас бусад төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн үр ашгийг нэмэгдүүлэх, цар тахлын үед төвлөрүүлээгүй ногдол ашгийн үлдэгдлийг бүрэн дайчлах замаар улсын төсөвт **48,000.0 сая** төгрөгийг нэмж төвлөрүүлэх.

Санал гаргасан Ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

68.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

ХОЁР.ТӨСВИЙН ЗАРДАЛ НЭМЭГДҮҮЛЭХ, БУУРУУЛАХ САНАЛ:

2.1.Төсвийн зардал бүүрүүлэх санал:

Дүн: 346,154.2 сая төгрөг

2.1.1.Нэгдсэн төсвийн ерөнхийлөн захирагчдын төсвийн төслийн нийт зарлагын зээлийн хүүгийн төлбөр, үйл ажиллагааны орлогоос бүрэн санхүүждэг зардлаас бусад урсгал зардлыг 1.88 хувиар буюу **320,416.0 сая** төгрөгөөр бууруулах;

2.1.2.Орчны бохирдлыг бууруулах үндэсний хороог татан буулгасантай холбогдуулан Эрчим хүчний сайдын төсвийн багцын урсгал зардлыг **25,738.2 сая** төгрөгөөр бууруулах;

Энэ чинь тэгээд бүгдийг нь багцалж хураах юм уу? Тийм ээ.

2.2.Төсвийн урсгал зардал нэмэгдүүлэх санал:

Дүн: 226,622.3 сая төгрөг

2.2.1.Монгол Улсын сайд, Боомтын сэргэлтийн Үндэсний хорооны ажлын албаны үйл ажиллагааны урсгал зардлыг **1,000.0 сая** төгрөгөөр нэмэгдүүлэх;

2.2.2.Улсын төсвөөс Говьсүмбэр аймагт олгох санхүүгийн дэмжлэгийн хэмжээг **1,000.0 сая** төгрөгөөр нэмэгдүүлэх;

2.2.3.Орчны бохирдлыг бууруулах үндэсний хороог татан буулгасантай холбогдуулан Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын төсвийн багцын орчны бохирдлыг бууруулах үйл ажиллагааны зардлыг **26,238.2 сая** төгрөгөөр нэмэгдүүлэх;

2.2.4.Орон нутаг, хөдөөгийн багуудын хөгжил, үйл ажиллагааг дэмжих зорилгоор хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээнд зориулж Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх

газрын даргын төсвийн багцын Сум, багийн хөгжлийг дэмжих үйл ажиллагааны зардлыг Төв аймагт **300.0 сая** төгрөг, Ховд аймагт **300.0 сая** төгрөгөөр тус тус нэмэгдүүлэх;

2.2.5.Аймгийн номын сангийн номын фондыг баяжуулах зорилгоор Соёлын сайдын төсвийн багцын номын зардлыг Төв аймагт **100.0 сая** төгрөгөөр нэмэгдүүлэх;

2.2.6.Сэлэнгэ аймгийн ерөнхий боловсролын сургуулийн номын сангийн фондыг баяжуулах зорилгоор Боловсрол, шинжлэх ухааны сайдын төсвийн багцын номын зардлыг **175.0 сая** төгрөгөөр нэмэгдүүлэх;

2.2.7.Үндсэн хуулийн цэц, шүүх, прокурорын 2016 оноос хойш нэмэгдүүлээгүй цалин хөлсийг нэмэгдүүлэхтэй холбоотойгоор Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн даргын төсвийн багцын цалингийн санг **233.0 сая** төгрөгөөр, Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн төсвийн багцын цалингийн санг **640.5 сая** төгрөгөөр, Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын төсвийн багцын цалингийн санг **11,100.1 сая** төгрөгөөр, Шүүхийн сахилгын хорооны даргын төсвийн багцын цалингийн санг **198.1 сая** төгрөгөөр, Улсын ерөнхий прокурорын төсвийн багцын цалингийн санг **17,506.1 сая** төгрөгөөр тус тус, нийт **29,677.8 сая** төгрөгөөр нэмэгдүүлэх;

2.2.8.Макро эдийн засгийн үндсэн үзүүлэлт, төлөв байдлын таамаглалыг боловсруулах чиг үүргийг хэрэгжүүлэх зорилгоор Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн үйл ажиллагааны зардлыг **800.0 сая** төгрөгөөр нэмэгдүүлэх;

2.2.9. Удирдлагын академид төрийн албан хаагчдыг сургах, хөгжүүлэх, чадавхжуулах үйл ажиллагаатай холбогдуулан Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын төсвийн багцын урсгал зардлыг **3,561.7** сая төгрөгөөр нэмэгдүүлэх;

2.2.10. Стандартчилал, хэмжил зүйн үндэсний төвийн урвалж бодисын зардалд зориулан Шадар сайдын төсвийн багцын урсгал зардлыг **500.0** сая төгрөгөөр нэмэгдүүлэх;

2.2.11. Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын төсвийн багцын урсгал зардлыг **8,108.0** сая төгрөгөөр нэмэгдүүлэх;

2.2.12. 2024 онд Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийг нэмэгдүүлэх зорилгоор Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын төсвийн багцын Нийгмийн даатгалын санд олгох татаасыг **140,661.6** сая төгрөгөөр нэмэгдүүлэх;

2.2.13. Аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлгийн тогтмол зардлыг санхүүжүүлэхтэй холбоотойгоор аймгуудын тогтмол зардлыг **14,200.0** сая төгрөгөөр нэмэгдүүлэх.

2.3. Хөрөнгийн зардалд өөрчлөлт оруулах санал:

Цэвэр өөрчлөлтийн дүн: 118,750.3 сая төгрөг

2.3.1. Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн төслийн 2 дугаар хавсралтад тусгагдсан 9 төсөл, арга хэмжээний 2024 онд санхүүжих дүнг хэрэгжилт, гүйцэтгэлийн явцтай

уялдуулан **98,000.0** сая төгрөгөөр саналын томьёоллын **1 дүгээр хавсралтын** дагуу бууруулах.

2.3.2. **Саналын томьёоллын 2 дугаар хавсралтад** тусгагдсан **800,889.4** сая төгрөгийн төсөвт өртөгтэй, **245,012.9** сая төгрөгийн 2024 онд санхүүжих дүнтэй 212 төсөл, арга хэмжээг 2024 оны төсвийн төсөлд шинээр нэмж тусгах.

2.3.3. Төсвийн төсөлд тусгагдсан 25 төсөл, арга хэмжээний төсөвт өртгийг **30,537.8** сая төгрөгөөр, 2024 онд санхүүжих дүнг **21,025.7** сая төгрөгөөр **саналын томьёоллын 3 дугаар хавсралтын 1 дэх хэсэгт** тусгасны дагуу, 11 төсөл, арга хэмжээний төсөвт өртгийг **203,858.7** сая төгрөгөөр **саналын томьёоллын 3 дугаар хавсралтын 2 дахь хэсэгт** тусгасны дагуу, 11 төсөл, арга хэмжээний 2024 онд санхүүжих дүнг **19,991.1** сая төгрөгөөр **саналын томьёоллын 3 дугаар хавсралтын 3 дахь хэсэгт** тусгасны дагуу тус тус нэмэгдүүлэх, мөн **саналын томьёоллын 3 дугаар хавсралтын 4 дэх хэсэгт** тусгасан 2 төслийн төсөвт өртгийг **34,992.7** сая төгрөгөөр нэмэгдүүлж, 2024 оны санхүүжих дүнг **3,000.0** сая төгрөгөөр бууруулах.

2.3.4. Монгол Улсын тухайн жилийн төсвийн тухай хуулиар өмнө нь батлагдан хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээний төсөвт өртгийн магадлалд хийсэн Үндэсний аудитын газрын аудитын дүгнэлтэд үндэслэн **саналын томьёоллын 4 дүгээр хавсралтын 1 дэх хэсэгт** тусгагдсан **284,078.1** сая төгрөгийн төсөвт өртөгтэй, **18,604.3** сая төгрөгийн 2024 онд санхүүжих дүнтэй 51 төсөл, арга хэмжээг 2024 оны төсвийн төсөлд шинээр нэмж тусгах, мөн төсвийн төсөлд тусгагдсан **саналын томьёоллын**

4 дүгээр хавсралтын 2 дахь хэсэг дэх 61 төсөл, арга хэмжээний төсөвт өртгийг **115,698.0 сая** төгрөгөөр, 14 төсөл, арга хэмжээний 2024 онд санхүүжих дүнг **10,489.1 сая** төгрөгөөр нэмэгдүүлэх, мөн төсвийн төсөлд тусгагдсан **саналын томьёоллын 4 дүгээр хавсралтын 3 дахь хэсэг дэх** 2 төсөл, арга хэмжээний төсөвт өртөг болон 2024 онд санхүүжих дүнг **738.6 сая** төгрөгөөр тус тус бууруулах.

2.3.5.Төсвийн төсөлд тусгагдсан 8 төсөл, арга хэмжээний төсөвт өртгийг **7,773.8 сая** төгрөгөөр, 2024 онд санхүүжих дүнг **5,873.8 сая** төгрөгөөр **саналын томьёоллын 5 дугаар хавсралтын 1 дэх хэсэгт** тусгасны дагуу, 51 төсөл, арга хэмжээний 2024 онд санхүүжих дүнг **71,820.7 сая** төгрөгөөр **саналын томьёоллын 5 дугаар хавсралтын 2 дахь хэсэгт** тусгасны дагуу бууруулах.

2.3.6.**Саналын томьёоллын 6 дугаар хавсралтад** тусгагдсан **32,480.3 сая** төгрөгийн төсөвт өртөгтэй, **16,939.9 сая** төгрөгийн 2024 онд санхүүжих дүн бүхий 15 төсөл, арга хэмжээг 2024 оны төсвийн төслөөс хасах.

2.3.7.Төсвийн төсөлд тусгагдсан төсөвт өртөг болон 2024 онд санхүүжих дүнд нөлөөлөхгүйгээр 33 төсөл, арга хэмжээний нэр, байршил, хүчин чадлыг **саналын томьёоллын 7 дугаар хавсралтад** тусгасны дагуу өөрчлөх.

Санал гаргасан Ажлын хэсэг.

Бөхчулууны Пүрэвдорж гишүүн.

Б.Пүрэвдорж: 2.2.12 дээр тэтгэвэр нэмэгдүүлэх зорилгоор Нийгмийн

даатгалын санд 140.0 тэрбумыг өгч байгаа.

Тэгэхээр энэ бол зөв байгаа. Яагаад гэвэл инфляцтай уялдуулан тэтгэврийг дараа жил нь нэмж байх ийм хуулийн зохицуулалт, Тэтгэврийг индексжүүлэх тухай хуулийн дагуу орсон байгаа.

Тэгэхээр 2022 оны 2 сарын 01-нд төсвийн тодотгол хийгээд тэтгэврийг 15 хувиар нэмсэн. Тэр үед яах вэ, 350 мянгатай байсан хүмүүс 500 мянган төгрөгийн тэтгэвэртэй болсон л доо.

Тэгэхдээ хамгийн гол нь өндөр тэтгэвэртэй хүмүүс нь 15 хувиар нэмэгдээд явчихсан учраас тэтгэврийн зөрүү улам ихэссэн гэж ахмадууд үзээд байдаг юм.

Тийм учраас сая Тэтгэврийг индексжүүлэх хуулийн дагуу 10 хувиар тэтгэвэр нэмэх шийдвэрийг Ерөнхий сайд санаачилга гаргаад болиулсан гэж ойлгож байгаа. Өөрөөр хэлбэл бага тэтгэвэртэй 550 мянган төгрөгийн тэтгэвэртэй хүмүүс 55 мянган төгрөгөөр нэмэгдэх юм байна. 2 сая төгрөгийн тэтгэвэртэй хүн 200 мянган төгрөгөөр нэмэгдэх нь.

Тийм учраас тэтгэврийн зөрүү улам өсөөд л явчихна гэдэг ийм болгоомжлол энэ Засгийн газрынханд очсон байх л даа.

Тийм учраас 100 мянга гэсэн нэрлэсэн үнээр тэтгэврийг нэмэгдүүлэх ийм шийдвэр гаргаж байна.

Тэгэхээр би тэр 2022 оны 2 сарын 01-нд тэтгэврийг 15 хувиар нэмэхдээ сая хүртлэхийг нь 20 хувиар, дээшээ 5, 5 хувиар багасгах замаар явсан бол илүү

тэтгэврийн зөрүү арилах байсан гэж үздэг юм.

Тийм учраас тийм санаачилга гаргаагүйдээ харамсдаг.

Тийм учраас 100 мянган төгрөгөөр нэмж байгаа тэтгэврээ 550-иас дээш сая төгрөгийн хооронд тэтгэвэртэй байгаа тэр хүмүүст 150 мянган төгрөгөөр нэмэгдүүлэх, 1 саяас 2 сая хүртэлх тэтгэвэр авч байгаа хүмүүсийг 100 мянган төгрөгөөр нэмэгдүүлэх, 2 сая төгрөгөөс дээш тэтгэвэр авч байгаа хүмүүсийн тэтгэврийг 50 мянгаар нэмэгдүүлэх ийм шийдвэр гаргахгүй бол болохгүй. Яагаад гэвэл бага тэтгэвэртэй хүмүүс нь дахиад л гомдсон хэвээрээ л үлдэх юм байна.

Тийм учраас үүний зөрүү ямар болох юм. Түүн дээр тодорхой шийдвэр, тооцоолол гаргаач ээ гэж Та бүхэнд хэлэх байна. Баярлалаа.

Г.Занданшатар: Зочид танилцуулъя.

Улсын Их Хурлын гишүүн Гонгорын Дамдинням, Болдын Жавхлан, Баагаагийн Баттөмөр нарын урилгаар Дархан-Уул аймгийн Ерөнхий боловсролын “Оюуны ирээдүй” сургуулийн багш нар Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Эрхэм хүндэт багш нартаа соён гэгээрүүлэх эрдмийн их ажилд нь өндрөөс өндөр амжилтыг хүсэн ерөөе. /алга ташив/

Одоо Баагаагийн Баттөмөр гишүүн үг хэлнэ. Баагаагийн Баттөмөр гишүүн.

Б.Баттөмөр: Төсвийн ажлын хэсэг ажиллаад 542.0 тэрбум төгрөгийн орлого нэмэгдүүлж, 335.0 тэрбум төгрөгийн зардлыг хасаж л орж ирж байна л даа.

Монгол Улсын хувьд хөрөнгө оруулалтыг эрэмбэлэх юм бол нэгдүгээрт эрүүл мэндийн салбар. Хоёрт нь, боловсролын салбар байсан.

Тэгээд би нэмэгдүүлэх санал дээр эрүүл мэндийн салбарт нэлээн хөрөнгө оруулалт орж ирэх болов уу гэж харж байсан юм. Орж ирсэнгүй л дээ.

Монгол Улс чинь “**ходоодны хорт хавдар**”, “**элэгний хорт хавдар**”, “**нойр булчирхайн хорт хавдар**”-аар 10 мянган хүнд ногдох тоогоороо дэлхийд тэргүүлж байгаа шүү дээ.

Баян хүмүүс нь мөнгөө гаргаад гадагшаа явчихдаг. Дундаж амьдралтай хүмүүс нь бүх юмаа зараад ядуурал руу ордог. Ядуу хүмүүс нь үхэж байгаа шүү дээ.

Тэгээд одоо нэг эрхтэн шилжүүлэхэд 145.0 тэрбум төгрөг. Тэр Төв аймагт нэг хавдрын эмнэлэг байгуулна. Тэрний шугам сүлжээнд 5.1 тэрбум төгрөг л явж байна шүү дээ.

Тэгээд ийм байж болохгүй л дээ. Одоо ер нь бол. Аймшигтай болчихсон байх.

Тийм учраас нэг номерт. Одоо Монгол Улсын төсвөөр шийдэж чаддаггүй юм бол тэр гаднын зээл, тусламжаараа Хавдрын эмнэлгийг тэр “**муу нэртэй, луу данстай**”

социализмын үед байгуулсан энэ эмнэлгүүдийнхээ материаллаг баазыг ашиглаад эмнэлгийг одоо хамгийн эхний ээлжид шийдэх ёстой. Маш олон хүн гадагшаа явж байна шүү дээ.

Хоёр дахь асуудал энэ ядуурал. Энэ төсвийн төсөл дотор ядуурлыг тэгж бууруулна, ингэнэ, ийм арга хэмжээ авна гэсэн тоо алга. Монгол Улсын нийт хүн амын 28 хувь нь ядуурчихсан. Дээр нь дахиад 14, 15 орчим хүн ядуурах магадлалтай.

Ялангуяа хөдөөгийн ард түмэн хотынхоос ядуурах магадлал 4 дахин их болчихсон байгаа шүү дээ.

Тэгээд ийм өвчтэй, өвчнөө эмчилж чаддаггүй. Дээрээс нь ийм ядууралтай мундаг ардчилсан улс гэж байхгүй шүү дээ.

Би сайд нараас асууя гэж бодсон юм. Тэгээд асуух горим байдаггүй юм байна. Үг хэлж байна.

Тийм учраас хэлж байгаа энэ ядууралтай тэмцэх ёстой.

Хоёрдугаарт нь, хавдрыг Монголд эмчлэх ёстой.

Хөгжлийн банкиг Солонгосууд өөрийнхөө менежментийн баг явуулаад зардлыг нь даагаад хийж байсан. Хөөж явуулж байгаад хувааж идсэн.

Одоо энэ гаднын байгууллагууд яагаад тавиад энэ хавдраа бид Монголдоо шийдье л дээ. Тэр эмнэлгийг нь байгуулъя, тоног төхөөрөмжийг нь оруулж ирье, хүмүүсээ сургая, лабораторийг нь байгуулъя, чанартай эмийг нь авч ирье.

Үүнийг шийдэхгүйгээр бид чинь баахан энд тэнд байшин, барилга барина гээд байх нь утгагүй байна шүү дээ.

Тийм учраас дараагийн юунууд дээр боломж байдаг юм уу, үгүй юу. Энэ дээр анхаарч өгөөч ээ. Анхаарахгүй бол ерөөсөө болохгүй асуудал болчихсон.

Г.Занданшатар: Зарчмын зөрүүтэй санал гэж байхгүй л дээ. Дэмжсэн, дэмжээгүй.

Гаргасан саналаа тайлбарлаж Дуламдоржийн Тогтохсүрэн гишүүн, Гочоогийн Ганболд гишүүн.

Г.Ганболд: Би энэ 2.3 хөрөнгийн зардалд өөрчлөлт оруулах санал дээр хоёр санал хэлье.

Цэвэр өөрчлөлтийн дүн нь 118 тэрбум 750.3 сая гэж байгаа юм.

Тэгээд эндээс харахаар эхний яг 2.3.1 дээр 9 төсөл, арга хэмжээнээс 98 тэрбумыг хассан байна.

2.3.2 дээр байна шүү дээ, 800 тэрбум 889.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 244 тэрбумын санхүүжих дүнтэй 212 төсөл, арга хэмжээ шинээр нэмсэн байна. Шинээр.

Бид зарчим л ярьсан. Эхнээсээ. Их Хурлын гишүүд тойрог дээрээ 3 орчим тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын санал өгөөрэй. Тэгээд дахиж Байнгын хороод дээр ч юм уу, өөр газар зарчмын зөрүүтэй санал гаргахгүй шүү гээд л бид нар дуугүй явцгаасан шүү дээ.

Гэтэл одоо ингээд бүр 212 төсөл, арга хэмжээ шинээр нэмсэн.

Тэгээд яг энэ 118.7 тэрбумын өөрчлөлтөөс би илүү л юм шиг харагдаад байх юм. Зүгээр нарийн тооцсон байлгүй. Дараагийнхыг нь харахаар.

Тэгээд үүнийгээ хэдүүлээ уг нь нэг зарчмаа бариад явчихсан бол их зүгээр байх юм. Зарим газар их өндөр төсөвт өртөгтэй юмнууд ч тавигдсан байх шиг. Тэгээд зарчмаа ингээд жаахан эвдээд яваад байхаар одоо үүнийг дэмжихэд хүндрэлтэй байна.

Ард нь 212 төслөө бүгдийг нь жагсаагаад тавьчихсан байна л даа.

Тэгээд үүнийгээ цаашдаа ер нь Их Хурлын гишүүдэд эхнээсээ хэлсэн зарчмынхаа юмнуудыг бариад явдаг байхгүй бол тэгээд ажлын хэсэг дээр юм уу, Төсвийн байнгын хороон дээр юм уу, асар их юм орж ирэхээр.

Өмнө нь өөрсдийнхөө хэлсэн зарчмын дагуу нэг жоохон санал хэлсэн гишүүд чинь хохиролтой байна шүү дээ.

Г.Занданшатар: Дуламдоржийн Тогтохсүрэн гишүүн.

Д.Тогтохсүрэн: Би ганц хоёр тайлбар хэлье. Араас нь үг хэлчихнэ.

Улсын төсвийг Засгийн газар өргөн барихдаа Халдвартын эмнэлгийг Төв аймагт Сэргэлэн суманд барихаар орж ирсэн.

Хавдрын эмнэлэг орж ирээгүй.

Хавдрын эмнэлгийг ажлын хэсэг дээр ярьж байгаад Хавдрын эмнэлгийг оруулсан.

Зохицуулалтын тухайд ийм байгаа. Бид яг л зарчим барьсан. Тэгэхдээ гишүүдийн хувьд өмнө нь өөрийн сум, дүүрэгт болон улсын хэмжээнд тавигдсан зарим нэгэн хөрөнгө оруулалтыг зохицуулалт хийх замаар шинэ хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, тэр нэмэгдлийн хөрөнгө оруулалт нь 212 объект болоод байгаа юм.

Тэр агуулгаар нь харах хэрэгтэй гэж би хэлмээр байгаа юм.

Одоо миний хэлэх гэж байгаа хоёр санал, хоёр тоон дээр.

Их Хурлын дарга аа,

Хоёр тоон дээр алдаа гарчихсан юм. Хоёр томъёолол дээр.

Яах вэ, ингээд бид нар чинь сүүлийн үед шахуу ажиллаж байна. Тэгээд өдөр, шөнөгүй л ажиллаж байна. Урьд шөнө Төсвийн байнгын хороо шөнийн 24 цаг хүртэл ажилласан. 00.00 цаг хүртэл ажилласан.

Ингээд ямар асуудал байна вэ гэхээр нэгдүгээрт нь төслийн 2.2.14-д байгаа аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлгийн тогтмол зардлаар санхүүжилттэй холбоотой аймгуудын тогтмол зардлыг тэр 11.2 гэсэн байгаа. Тэр 14.2 тэрбум төгрөг байгаа юм. 14.2 байгаа юм.

Тооцоолол нь ингэж хийгдээд, балансууд бол яг одоо түрүүн нөгөө төсвийн хүрээний. Бид түрүүн төсвийн хүрээний мэдэгдэл баталсан шүү дээ. Энэ тоон дээр ингээд батлагдчихсан юм.

Өчигдөр нөгөө Байнгын хорооны хурал дээр бид нар танилцуулахдаа 11.2-

оор яваад ингээд Та бүхэн санасан байхдаа. С.Чинзориг сайд л орой миний юм буурчихсан байна гээд байдаг чинь энэ байсан юм.

Тийм учраас одоо би таныг боломж байвал 14.2 гэж залруулж ойлгоно гээд саналаа хураачихвал энэ болох байгаа юм.

Бүх юунууд ингээд хийгдчихсэн юм. Тооцооллууд.

Хоёр дахь асуудал нь, саналын томьёоллын 4 дүгээр хавсралтын 1 дэх хэсгийн 28 дугаарт байгаа Эрүүл мэндийн төвийн 2 барилгын хоорондын санхүүжилтийн дүн зөрүүтэй тавигдчихсан байгаа юм. Үүнийг засахгүй бол дараагийн хэлэлцүүлгээр засаж болдоггүй юм.

Тэгээд нөгөө гишүүд нь санал тавиад байгаа юм. Тухайлбал, 28 дугаар мөрөнд туссан Эрүүл мэндийн төвийн барилга, өргөтгөл, Увс аймгийн Давст сум, 2024 онд санхүүжих дүн 285.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 50 дугаар мөрөнд тусгагдсан Эрүүл мэндийн төвийн барилга 15 ор, Завхан, Яруу сум гэсэн төслийг 2024 онд санхүүжих дүн 285-аар бууруулах ийм зохицуулалт хоёрыг та одоо санал дотроо хэлээд явчихвал энэ ингээд засагдчих юм.

Ингэхгүй бол энэ хоёрын нөгөө засвар, засалт хийгдэхгүй ингээд явчих гээд байгаа юм.

Бид нар өмнө нь ч гэсэн бас нэг гашуун туршлага бий. Өөр газар юм өөр газар луу явчихдаг нэг ийм харагддаг. Ийм учраас ийм хоёр зохицуулалт байгаа юм.

Энэ хоёрыг одоо та хэлж өгөөд, энэ хоёрыг тооцож санал хураагдаж байгаа шүү гэгчхвэл дэгийн хуулийн дагуу дэг зөрчигдөхгүй болно гэж манай Тамгын газрынхан зөвлөж байгаа юм. Баярлалаа.

Г.Занданшатар: Энэ одоо нэгэнтээ уншчихсан юмыг гүйцээн боловсруулж янзлахгүй бол ингээд засаад. Одоо ахиад бүгдийг нь эхнээс нь унших болно шүү дээ.

Байнгын хорооныхтойгоо зөрчил гарч байгаа юм билээ.

Тэгээд Байнгын хороон дээр хураалгасан саналыг энд өөрчиллөө гээд бас төсвийнхөн ажил үүсгээд байна л даа.

Тэгэхдээ байна шүү дээ. Энэ төсвийн шинжилгээний албаны гаргасан дүгнэлтээр Төсвийн тухай хуулийн 29.3.3-ыг зөрчилтэй. Нэлээн том хөрөнгө оруулалт бий.

Төсвийн тухай хуулийн 29.3.5-д заасан шинээр эхлэх барилга, байгууламж, хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээ нь гагцхүү хэрэгжүүлэх хугацаанд тэнцүү, хуваарилсан хэмжээнээс багагүй байхаар тооцно гэсэн заалтыг ч гэсэн.

606.7 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 94.3 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй төсөл, арга хэмжээнүүд нь хууль зөрчиж байна гээд ингээд дүгнэлт гарсан.

Тэгээд хууль зөрчсөн юм бид баталчихаар сүүлд нь энэ асуудал үүснэ. Эхнээсээ хууль тогтоох байгууллага хуулиа зөрчихгүй.

Гэтэл энэ 225 арга хэмжээг харсан чинь одоо Ховдод байгаа тэр 10-аад тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт нэмэгдсэн.

Жишээлбэл, ногоон байгууламж бүхий орчны тохижилт. Энэ Төрийн хэмнэлтийн тухай хуулийн зөрчилтэй маш их саналууд байна.

Төсвийн төсөл дээр ч байсан. Энэ дээр ч байсан. Ингээд хууль зөрчөөд яваад байх юм бол Төрийн хэмнэлтийн тухай хууль ер нь байх хэрэг байгаа юм уу. Нэг хууль батлаад ингээд.

Ховд аймгийн сум, багуудад ногоон байгууламж бүхий орчны тохижилт 3 тэрбум төгрөг, 2 тэрбум төгрөгөөр санхүүжнэ гээд.

Ингээд Ховдод баахан тохижилт хийх нь л дээ. Сая Б.Пүрэвдоржийн яриад дуугүй болчихдог чинь энэ л юм шиг байгаа юм.

Тэгэхээр энэ чинь Ховд аймгийн цагдаагийн газрын барилга гэхэд 8.5 тэрбум төгрөг, санхүүжих дүн нь 1.7 тэрбум төгрөг. Гуравны нэгийг нь доошгүй тавих ёстой.

Гэх мэтчилэн энэ чинь дандаа Төсвийн тухай хуулийн 29.3, 29.3.5, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн тухай хуулийн 20 дугаар зүйлд заасан зөрчилтэй ийм хууль бид баталж болох юм уу гэсэн асуулт үүсэж байна л даа.

Тэгээд үүнийгээ ер нь тэгээд хянан үзэж, гүйцээн боловсруулахгүй бол миний хувьд хуулийн зөрчилтэй санал хураалтууд явуулах нь ёс зүйн хүнд байна.

Тэгээд энэ дээрээ тайлбар өгвөл сайн байна. Д.Тогтохсүрэн дарга.

Яах юм? Одоо тэгээд саяын тоонуудыг засчихсан юм байна. Тэгэхдээ Байнгын хороон дээрээ тэрийгээ засах ёстой.

Тийм учраас энэ санал хураалтад би оролцох бололцоогүй юм байна.

29.3.3 бол гурав, гурваа янзалсан байж магадгүй. Тэгэхдээ энэ дээрээ ахиад энэ шинэ заалтууд дээр чинь ороод ирсэн байна л даа.

Тэр замуудыг бол ойлгосон. Л.Мөнхбаатар дарга та хурал удирдчих.

Би энэ хууль зөрчсөн санал хураалт явуулж чадахгүй.

Л.Мөнхбаатар: Зарчмын зөрүүтэй саналтай холбогдуулж 3 гишүүн үг хэллээ.

Саналын томъёоллыг уншиж танилцуулсан. Санал хураалт. Гишүүд саналаа өгөөрэй.

61.5 хувиар санал дэмжигдлээ.

ГУРАВ.ЗАРЧМЫН БУСАД САНАЛ:

3.1.Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн төсөлд өөрчлөлт оруулах:

3.1.1.Төслийн 10 дугаар зүйлийн **“1,231,447.7 сая төгрөг,”** гэснийг **“1,231,447.7 сая төгрөг байна.”** гэж өөрчлөх.

Санал гаргасана Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

67.9 хувиар санал дэмжигдлээ.

3.1.2.Төслийн 11 дүгээр зүйлийн
“2,788,332.7 сая төгрөг,” гэснийг
“2,788,332.7 сая төгрөг байна.” гэж
өөрчлөх.

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

66.7 хувиар санал дэмжигдлээ.

**3.2.Монгол Улсын 2024 оны
төсвийн тухай хуулийн төслийн 1
дүгээр хавсралтад өөрчлөлт
оруулах:**

3.2.1.Төслийн 1 дүгээр хавсралтын гарчгийг “Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2024 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлт” гэж, мөн хавсралтын 11.1 дэх хэсгийн “70102 Хууль тогтоох, хуулийн хэрэгжилтэд хяналт тавих” гэснийг “70204 Санхүүгийн зах зээлийн зохицуулалт” гэж, 11.2 дахь хэсгийн “Хөтөлбөр” баганын “11.2.1, 11.2.2” гэсэн дугаарыг “11.1.3, 11.1.4” гэж, 16.2 дахь хөтөлбөрийн 16.2.5 дахь хэсгийн “2024 оны зорилтот түвшин” баганын “Илтгэх хуудас” гэснийг “Илтгэх хуудас-1” гэж, 20.5.1 дэх хөтөлбөрийн 20.5.1.1 дэх хэсгийн “2024 оны зорилтот түвшин” баганын “7” гэснийг “300/7” гэж, 20.6.1 дэх хөтөлбөрийн “Шалгуур үзүүлэлт” баганын “цэвэрлэгээний ажлын хэмжээ” гэснийг “цэвэрлэгээ” гэж, 21.1.2 дахь хөтөлбөрийн “Хөтөлбөрийн зорилт, хүрэх үр дүн” баганын “өргөжихийн хирээр” гэснийг “өргөжүүлж” гэж, 21.2.1 дэх хөтөлбөрийн “2024 оны зорилтот

түвшин” баганын “5.0” гэснийг “6.0” гэж, 23.5.1 дэх хөтөлбөрийн 23.5.1.5 дахь хэсгийн “2024 оны зорилтот түвшин” баганын “45,700.0” гэснийг “45,000.0” гэж, 23.8.1 дэх хөтөлбөрийн “Шалгуур үзүүлэлт баганын “хууль” гэснийг “хуулийн төсөл” гэж, 26.6.1 дэх хөтөлбөрийн 26.6.1.5 дахь хэсгийн “Хэмжих нэгж” гэсэн баганын “жин” гэснийг “хувь” гэж, 28.3.1 дэх хөтөлбөрийн 28.3.1.1 дэх хэсгийн “2024 оны зорилтот түвшин” баганын “51.1” гэснийг “65.3” гэж, 29.3.1 дэх хөтөлбөрийн 29.3.1.1 дэх хэсгийн “хууль” гэснийг “хуулийн төсөл” гэж, 36.1.1 дэх хөтөлбөрийн 36.1.1.1 дэх хэсгийн “хамрагдаж” гэснийг “хамрагдсан хүмүүст” гэж, 37.1.1 дэх хөтөлбөрийн 37.1.1.1, 37.1.3 дахь хөтөлбөрийн 37.1.3.1, 37.1.3.3 дахь хэсгийн “хувь” гэснийг “явц” гэж, 38.1 дэх хэсгийн “70501 Орон нутгийн төсөвт олгох орлогын шилжүүлэг” гэснийг “71105 Авто тээврийн хяналт, зохицуулалт, үйлчилгээ, нийтийн тээвэр” гэж тус тус өөрчлөх, хөтөлбөр, хөтөлбөрийн зорилт, хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлтэд өөрчлөлт орсонтой холбогдуулан дугаарлалтын өөрчлөлт оруулах.

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

66.7 хувиар санал дэмжигдлээ.

3.2.2.Төслийн 1 дүгээр хавсралтын 11.2 дахь хэсгийн “70104 Ерөнхийлөгч, хууль тогтоох болон гүйцэтгэх засаглалын удирдлагын судалгаа шинжилгээ” гэснийг, мөн хэсгийн “11.2” гэсэн дугаарыг, 28.1 дэх хэсгийн 28.1.2 дахь хөтөлбөр буюу “Нийт мал сүрэгт өндөр ашиг шимт малын эзлэх хувийг нэмэгдүүлнэ.” гэсэн зорилт, хүрэх үр дүнг 28.1.2.1, 28.1.2.2 дахь хэсгийн

шалгуур үзүүлэлт, хэмжих нэгж, суурь он, суурь түвшин, 2024 оны зорилтот түвшингийн хамт бүхэлд нь, 28.4 дэх хэсгийн 28.4.1 дэх хөтөлбөрийн 28.4.1.3 дахь хэсгийн “Дорнод үйлдвэрлэл технологийн паркийн бүтээн байгуулалтын явц” гэсэн шалгуур үзүүлэлтийг хэмжих нэгж, суурь он, суурь түвшин, 2024 оны зорилтот түвшингийн хамт бүхэлд нь, 34.1.1 дэх хөтөлбөрийн 34.1.1.1 дэх хэсгийн “мянгаар” гэснийг тус тус хасах.

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

69.8 хувиар санал дэмжигдлээ.

3.2.3.Төслийн 9.1.3 дахь хөтөлбөрийн “Шалгуур үзүүлэлт” баганын “төлөвлөгөөний” гэсний дараа “тухайн оны” гэж, 29.7.1 дэх хөтөлбөрийн 29.7.1.3 дахь хэсгийн “нээсэн” гэсний дараа “хүүхдэд” гэж нэмэх.

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

66.0 хувиар санал дэмжигдлээ.

3.3.Бусад санал:

3.3.1.Орлого нэмэгдүүлэх, урсгал зардал болон хөрөнгийн зардалд өөрчлөлт орж байгаатай холбогдуулан Төсвийн ерөнхийлөн захирагч нарын төвлөрүүлэх орлого, зарцуулах зардалд болон орон нутгаас улсын төсөвт төвлөрүүлэх орлого, орон нутагт улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгийн хэмжээг саналын томъёололтой уялдуулан тооцоолол хийж, хуулийн дагуу холбогдох өөрчлөлтийг хийх.

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

73.6 хувиар санал дэмжигдлээ.

3.3.2.Төсөлд зүйл, заалт нэмэгдэх, хасагдах, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төсөвт өртөг, санхүүжих дүнд өөрчлөлт оруулах, нэр, хүчин чадал, байршлыг өөрчилсөнтэй уялдуулан хуулийн төслийн дугаарлалт, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний дугаар, хэрэгжих хугацаа, эдийн засгийн ангилал, Төсвийн ерөнхийлөн захирагч хооронд холбогдох өөрчлөлтийг оруулах.

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

68.9 хувиар санал дэмжигдлээ.

3.3.3.Төсөлд шинээр тусгагдсан төсөл, арга хэмжээний төслийн кодыг Сангийн яамны төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим системээс бэлтгэн төслийн 2 дугаар хавсралтын “Төслийн код” баганад харгалзуулан тусгах.

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

67.9 хувиар санал дэмжигдлээ.

3.3.4.Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн төслийн хамт өргөн мэдүүлсэн Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хонины ноос, тэмээний ноос, сарлагийн хөөврийн килограмм тутамд тоохон мөнгөн урамшуулал олгохоор төсвийн тооцоололд тусгагдсантай холбогдуулан Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 40

дүгээр зүйлд заасныг үндэслэн Улсын Их Хурлын 2011 оны 30 дугаар тогтоолын холбогдох заалтад өөрчлөлт оруулах Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулж Байнгын хороо, нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх.

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

76.9 хувиар санал дэмжигдлээ.

3.3.5.Төсвийн шинэчлэл болон төсвийн тооцоололд өөрчлөлт орсонтой холбоотой, мөн Монгол Улсын 2024 оны төсвийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн төслүүдийн хэлэлцүүлгийн явцад гарсан саналын томъёоллолтой холбогдуулан Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 40 дүгээр зүйлд заасныг үндэслэн холбогдох хууль тогтоомжийн төслийг боловсруулж Байнгын хороо, нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх.

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

71.2 хувиар санал дэмжигдлээ.

3.3.6.Саналын томъёоллын 2 дугаар хавсралтад тусгагдсан “Шинэ сэргэлт” Ховд төслийн тоног төхөөрөмж /Ховд/ төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 40.9 сая төгрөгөөр бууруулж, хөрөнгө оруулалтын хавсралтад Өв соёл, хүндэтгэлийн өргөө /Ховд, Үенч сум/, хэрэгжих хугацаа 2020-2024, төсөвт өртөг 150.0 сая төгрөг, 2024 онд санхүүжих дүн 40.9 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг нэмэгдүүлэх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж. Санал хураалт. /алх цохив/

69.2 хувиар санал дэмжигдлээ.

3.3.7.Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн төслийн 2 дугаар хавсралтын IX.1.3.1-д тусгагдсан “Гаалийн шинэчлэл-Гаалийн ерөнхий газар, газар хороодын шуурхай удирдлагын төв, хяналт шалгалтын тоног, төхөөрөмж, дэд бүтцийн хамт /Улсын хэмжээнд/” гэсэн төсөл, арга хэмжээний 2024 онд санхүүжих дүнг 500.0 сая төгрөгөөр бууруулж, хөрөнгө оруулалтын хавсралтад “Сумын төвын доторх 1.5 км хатуу хучилттай авто зам /Архангай, Хайрхан сум/, хэрэгжих хугацаа 2024-2026, төсөвт өртөг 1,500.0 сая төгрөг, 2024 онд санхүүжих дүн 500.0 сая төгрөг” гэсэн төсөл арга хэмжээг нэмэх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяа. Санал хураалт. /алх цохив/

75.0 хувиар санал дэмжигдлээ.

Саяынх бол Төсвийн байнгын хорооны дэмжсэн саналууд байсан. Одоо Төсвийн байнгын хорооны дэмжээгүй санал шүү.

Ингээд гишүүд саналаа өгөхдөө бас анхааралтай өгөөрэй. Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналуудыг одоо хураалгах гэж байна. Бусад Байнгын хорооноос ирүүлсэн зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалгая.

НЭГ.БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН ХОРОО

1.Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн төслийн 2 дугаар хавсралтын “VI.I.8.Аялал жуулчлалын

байгаль, түүх, соёлын өв бүхий газруудад ариун цэврийн байгууламж, авто зогсоол бүхий отоглох цэг /Улсын хэмжээнд/, төсөвт өртөг 2,325.0 сая төгрөг, 2024 онд санхүүжих дүн 2,325.0 сая төгрөг” гэсэн төсөл арга хэмжээний төсөвт өртөг, санхүүжих дүнг 374.1 сая төгрөгөөр бууруулж, “Аялал жуулчлалын байгаль, түүх, соёлын өв бүхий газруудад ариун цэврийн байгууламж, авто зогсоол бүхий отоглох цэг /Булган аймаг, Рашаант сум, Элсэн тасархай/, төсөвт өртөг 374.1 сая төгрөг, 2024 онд санхүүжих дүн 374.1 сая төгрөг” гэсэн төсөл арга хэмжээ шинээр нэмж тусгах.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ц.Анандбазар. Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо дэмжээгүй санал байна.

Үг авах юм уу? Бөхчулууны Пүрэвдорж үг хэлье. Саналын томьёоллыг уншиж танилцуулсан.

Одоо саналын томьёолол чинь ингэж уншигдана шүү. Гишүүд ээ, анхааралтай байж байгаарай.

Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураана. Тийм.

Саналын томьёоллыг уншиж танилцуулсан. Санал хураалт. /алх цохив/

60.8 хувиар санал дэмжигдлээ.

ХОЁР.БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН БАЙНГЫН ХОРОО

1.Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн төслийн 2 дугаар хавсралтын XIV.3.10.Соёлын салбарын

тоног төхөөрөмж /Улсын хэмжээнд/-ийн зардлыг 200.0 сая төгрөгөөр бууруулж, төсөлд “Сэлэнгэ аймгийн Алтанбулаг сумын музейн засварт 2024 он, 200.0 сая төгрөг” гэж нэмэх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ч.Ундрам. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороо дэмжээгүй санал байна.

Дэмжээгүй саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураая. /алх цохив/

66.7 хувиар санал дэмжигдлээ.

2.Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн төслийн 2 дугаар хавсралтын XIV.3.10. Соёлын салбарын тоног төхөөрөмж /Улсын хэмжээнд/-ийн зардлыг 400.0 сая төгрөгөөр бууруулж, төсөлд “Сэлэнгэ аймгийн соёлын салбарын тоног төхөөрөмжид 2024 он, 400.0 сая төгрөг” гэж нэмэх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ч.Ундрам. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороо дэмжээгүй санал байна. Санал хураалт. /алх цохив/

Дэмжээгүй саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хурааж байгаа шүү.

66.7 хувиар санал дэмжигдлээ.

БУСАД САНАЛ

1.Нэгдсэн төсвийн ерөнхийлөн захирагчдын төсвийн төслийн нийт зарлагын Нийгмийн даатгалын сан, зээлийн хүүгийн төлбөр үйл ажиллагааны орлогоос бүрэн санхүүждэг зардлаас

бусад урсгал зардлыг 0.76 хувиар буюу 93,000.0 сая төгрөгөөр бууруулж, 2018-2023 оны хооронд 6 болон 7 жилийн цалингийн дунджаар тэтгэвэрээ тооцуулсан 58.0 мянган иргэний тэтгэврийн нөхөн олговор 93,000.0 сая төгрөгийг Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсөвт тусгах.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж. Санал хураалт.

Зөвхөн санал гаргасан гишүүн л саналаа тайлбарлаж үг хэлж болно. Бөхчулуун Пүрэвдорж үг хэлье. Болохгүй юм байна. Дэгээрээ Бөхчулууны Пүрэвдорж л үг хэлэх боломжтой байна.

Б.Пүрэвдорж: 2018-2023 оны хооронд 5 жилийн хугацаанд тэтгэвэрээ 6 болон 7 жилийн цалингийн дунджаар бодуулсан энэ 58 мянган иргэн төрийн буруутай үйл ажиллагаанаас болж хохирч үлдэх ёсгүй гэж үзэж байгаа.

Тийм учраас Их Хурлын гишүүдийг хөдөө орон нутагт явахад энэ асуудлаараа байнга асуулт асууж, захиас өгч байгаа. Харамсалтай нь энэ асуудлыг яг ингээд мөнгө төгрөг нь ороод ирэхээр дэмжихгүй тал байгаад байна.

Энэ 58 мянган иргэнд 93 тэрбум төгрөг олгох учиртай.

Тэр нь нэг иргэнд дунджаар 1 сая 600 мянган төгрөг очих ёстой юм.

Манай Монгол төр чинь нийгмийн даатгалын шимтгэл авах болохоороо маш их өндрөөр авчихаад өгөх болохоороо хамгийн бага тэтгэвэр өгнө гэдэг ийм харгис төр байж болохгүй.

Тийм учраас энэ буруутай шийдвэр гаргасан энэ асуудалдаа төр анхаарч энэ амьд бурхад болсон ахмадууддаа, 58 мянган ахмаддаа 93 тэрбум төгрөгийн нөхөн олговрыг олгох ийм зайлшгүй шаардлага гарч ирж байна.

Хэдийгээр Нийгмийн даатгалын багц хуулийг 7 сарын 01-нд батлахдаа нөхөж 5 жилээр бодох сайн шийдвэр гаргасан боловч нөхөн олговрыг олгох энэ шийдвэрийг гаргаагүй.

Тийм учраас энэ адилхан органик хууль. Төсвийн хуулиар энэ асуудлыг шийдээд явах ийм боломжтой. Тэгээд үүнийхээ дагуу би Төсвийн байнгын хороон дээр зарчмын зөрүүтэй санал гаргасан боловч дэмжээгүй.

Тийм учраас Их Хурлын гишүүд Та бүхнийг бас бүгдээрээ ахмадуудтай. Тэр хүмүүстээ бэлэг барьж энэ асуудлыг дэмжихгүй байж энэ 93 тэрбум төгрөгийг ахмадууддаа. Төрийн буруутай үйл ажиллагааны шийдвэрийн үр дүнд гарсан тэр нөхөн олговрыг олгохыг дэмжээч ээ гэж хүсэж байна.

Л.Мөнхбаатар: Энэ саналыг Төсвийн байнгын хороо дэмжээгүй. Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураая. Санал хураалт.

60.8 хувиар санал дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хурааж дууслаа.

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн

тухай хуулийн төслүүдийг гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүллээ.

Төсвийн байнгын хороо маргааш 09.00 цагаас уу? Тийм ээ. Өглөө 09.00

цагаас Төсвийн байнгын хороо хуралдана.

Өнөөдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул чуулганы нэгдсэн хуралдаан өндөрлөснийг мэдэгдье. /алх цохив/

Хуралдаан 1 цаг 56 минут үргэлжилж, 17 цаг 40 минутад өндөрлөв.

**БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ**

Ц.АЛТАН-ОД
